





# 2020 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

Эрдэс баялгаас эрдэм  
мэдлэг, ур чадвар, үнэт  
зүйлс бүтээлцэнэ





**Аюулгүй ажиллагааг  
хангах нь “Оюу толгой”  
компанийн нэн тэргүүний  
зорилт билээ. Эрсдэлтэй  
ямар ч ажлыг шууд  
зогсооно.**




# АГУУЛГА

Оны товчоон	6
Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ	8
Гүйцэтгэх захирал, Гүний уурхайн төслийн захирлын мэндчилгээ	10
Компанийн тухай	12
Алсын хараа, манай ирээдүй	13
Санхүүгийн гүйцэтгэл	16
Зохистой зарцуулалтын арга хэмжээ	18
Ханган нийлүүлэлтийн сүлжээ	19
Аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд болон байгаль орчин	22
Аюулгүй байдал ба гэнэтийн аюулд хариу үзүүлэх тогтолцоо	25
Дэлхийд өрсөлдөхүйц үйлдвэрлэл	28
Мэргэшсэн ажиллах хүчин	29
Түншлэгч талуудын хамтын ажиллагаа	36
Стратеги хөгжил	41
Эрчим хүч	44
Маркетинг ба борлуулалт	46
КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ	47
Төлөөлөн удирдах зөвлөл	50
Гүйцэтгэх удирдлагын баг	50
2020 оны ТУЗ, хороод, хувьцаа эзэмшигчдийн хурлын товчоон	51

# ОНЫ ТОВЧООН<sup>1</sup>

## Бүх гэмтэл бэртийн давтамжийн үзүүлэлт (БГДҮ)


(200,000 хүн/цаг)



2020 оны эцсийн байдлаар 200,000 хүн/цагт ногдох бүх гэмтэл, бэртийн давтамж (БГДҮ) 0.15 хүртэл буурч, уг үзүүлэлтээр Рио Тинто группийн хэмжээнд тэргүүлэх уурхайн нэг хэвээр байна.

## Баяжмал үйлдвэрлэл


(мян.тонн, хуурай жингээр)



Эс, алтны агуулга сайтай хэсгийн олборлолт 2021 оны турш үргэлжлэх төлөвтэй байна.

## Баяжмалын борлуулалт


(мян.тонн, хуурай жингээр)



2019 онтой харьцуулахад борлуулалт буурсан нь 2020 оны хоёр, арваннэгдүгээр саруудад КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хилийн нэвтрэлт хязгаарлагдсанаас үүдэлтэй.

## Урсгал капитал


(сая ам.доллароор)



Урсгал капиталын зардал 2019 оныхоос 76 сая ам.доллароор буурсан. Уурхайн олборлолтын дарааллыг өөрчлөн, 4В үе шатыг түлхүү олборлосноор хөрс хуулалтын зардал 43 сая ам.доллароор, урсгал капиталын төслүүдийн зардал 26 сая ам.доллароор мөн засвар үйлчилгээний зардал 8 сая ам.доллароор тус тус буурсан нь үүнд гол нөлөө үзүүлсэн.

## Бүтээн байгуулалтын капитал

(сая ам.доллароор)



КОВИД-19 цар тахлын улмаас гадаад мэргэжилтнүүдийн ээлж солилцох хөдөлгөөнд хязгаарлалт тавигдсанаас үүдэн Гүний уурхайн капитал зардал өмнөх оныхоос 184 сая ам.доллароор буурч, 2020 онд 1 тэрбум 10 сая ам.доллар байв.

<sup>1</sup> Санхүүгийн хураангуйлсан үзүүлэлтүүдийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу боловсруулан гаргасан "Оюу толгой" ХХК-ийн 2016, 2017, 2018, 2019, 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдлын аудитаар баталгаажсан тайлангаас авсан болно. Аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг боловсруулахдаа "Оюу толгой" компанийг бие даасан бизнесийн нэгжийн түвшинд авч үзсэн бөгөөд уг тайланд тусгасан мэдээлэл нь дүнгийн тохируулах бичилт, нягтлан бодох бүртгэлийн бусад ялгаанаас шалтгаалаад "Туркойз Хилл Ресурс" болон "Рио Тинто"-ийн тайланд тусгасан мэдээллээс зөрүүтэй байж болохыг анхаарна уу.

### Татвар, хураамж, бусад төлбөр

(2010 - 2020, сая ам.доллар)




2010 - 2020 оны хооронд Монголын ханган нийлүүлэгчдэд төлсөн НӨАТ болон бусад татвар, хураамжид нийт 2.9 тэрбум ам.доллар төлсөн. 2020 онд татвар, хураамж болон бусад төлбөрт 294 сая ам.доллар төлжээ.

\* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

### Дотоодод зарцуулсан нийт мөнгөн хөрөнгө


(2010 - 2020)



2010 - 2020 оны хооронд дотоодын компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалин 11.6 тэрбум ам.доллар давлаа.

### Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалт

(2010 - 2020, сая ам.доллар)




2020 онд Өмнөговь аймагт бүртгэлтэй 84 ханган нийлүүлэгч манайд бараа, үйлчилгээ нийлүүлэв. 2010 - 2020 онд Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалтад нийт 672 сая ам.доллар зарцуулжээ.

### Үндэсний худалдан авалт

(2010 - 2020, сая ам.доллар)


Өсөн нэмэгдсэн дүнгээр **3.54** тэрбум ам.доллар



2020 онд үйл ажиллагааны худалдан авалтын баг 770 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 499 нь үндэсний аж ахуйн нэгж байсан бөгөөд тэд нийт худалдан авалтын 72 хувийг бүрдүүлж байна. 2010-2020 онд үндэсний худалдан авалтад 3.54 тэрбум ам.доллар зарцуулсан.


### Усны хэрэглээ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)



### Ус дахин ашиглалт

(хувь, сараар)



# Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ



Оюу толгойчууд XXI зууны 20 дахь онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө нар, сартай уралдан зүтгэсний дүнд үйл ажиллагаагаа жигд үргэлжлүүлж, гүний уурхайнхаа бүтээн байгуулалтыг амжилттай урагшлуулж чадсаныг бахархан мэндчилж байна.

Гэхдээ улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, амь амьжиргааны хувьд цар тахалд нэрвэгдсэн нь уул уурхайн салбар, түүний дотор манай хэвийн үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад амаргүй сорилт бэрхшээл учруулсныг тэмдэглэх нь зүйтэй. Төр, засгийн төв болоод орон нутгийн байгууллагуудын халуун дэмжлэг, тус компанийн хөдөлмөрч хамт олон, гэрээт компаниуд, хамтран ажиллагч талуудын хамтын чармайлтын хүчинд тулгарсан хүндрэл, сорилтыг даван туулсныг онцлон дурдъя.

Цар тахлын бэрх цаг үед Баяжуулах үйлдвэрийнхээ ээлжит засвар үйлчилгээг аюул осолгүй, чанартай, хугацаанд нь гүйцэтгэх чимхлүүр ажлыг анх удаа дан монгол мэргэжилтнүүдийн баг амжилттай хийж гүйцэтгэснийг дээрх хамтын амжилтын жишээ болгож тэмдэглэе. Гадаадын мэдлэг, туршлагатай мэргэжилтэн нараас чадварлаг суралцаж буй үндэсний инженер, техникийн залуу үеийнхнээр бахархнам.

Тус компанийн үйлдвэрлэлийг олон улсын жишиг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэж "Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч"-ийн батламж олгосон нь манай хамт олон, гүйцэтгэх удирдлагын багийн хичээл зүтгэлийг үнэлсний гэрч юм.

Төслийн хүрээнд эдүгээ хүртэл дотоодод нийт 11.6 тэрбум ам.доллар зарцуулаад буй үзүүлэлт нь үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулж буйг харуулж буй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс улирч буй онд ажилчдын чадавх, ур чадварын өсөлт, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, эрчим хүчний зарим хэрэглээг дотоодоосоо хангах зэрэг цөөнгүй ажлыг уурхайн цогцолборын стратегийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу гүйцэлдүүлэхэд эрмэлзэж ажилласан билээ.



Рио Тинто, Туркойз Хилл Ресурс компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ манай уурхайд анх удаа цахим дэглэмд зочилж үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын явц байдалтай танилцсан нь чухал ач холбогдолтой болов.

Цаашид өмнөх жилүүдийнхээ амжилтыг улам бататгахын зэрэгцээ гүний уурхайн бүтээн байгуулалтын үндсэн нэг хэсэг болох уулын огтолгооны ажлыг эхлүүлэхэд чиглэсэн бэлтгэлийг бүхэлд нь хангалаа.

Тиймээс хувь нийлүүлэгчдийн хэлэлцээ амжилттай болж, гүний уурхайн бүтээн байгуулалтыг улам эрчимжүүлэх, түүнийг төлөвлөгдсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зорилтоо хэрэгжүүлэх боломж бүрдэнэ гэдэгт Оюу толгойчууд итгэл төгс байгаа болно.

Оюу толгойн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтыг тасралтгүй үргэлжлүүлэх боломжоор хангаж, дэмжиж ирсэн хувьцаа эзэмшигчид болоод төр засаг, улс, орон нутгийн онцгой комиссын бүх шатны албан хаагчдад гүн талархал илэрхийлье.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга  
Элчин Сайд Галсангийн Батсүх  
(Олон улсын харилцааны доктор)

# Гүйцэтгэх захирал, Гүний уурхайн төслийн захирлын МЭНДЧИЛГЭЭ

2020 онд дэлхий нийтээрээ урьд өмнө тулгарч байгаагүй шинэ сорилт бэрхшээлтэй нүүр тулсан билээ. “Оюу толгой” компани ч үүнийг тойрч гарсангүй. КОВИД-19 цар тахлаас шалтгаалан бид ажлын шинэ хэлбэр, арга барилд суралцаж байна. Хамт олны маань цөөнгүй хэсэг уурхайн цогцолбор дээр уртасгасан хуваариар, хэдэн долоо хоног сунан ажиллаж, зарим нь гэрээсээ ажиллахын хажуугаар ахуй амьдралаа зохицуулж, олон улсын нислэг зогссоны улмаас зарим нь гэр бүлээсээ олон сараар хол байх шаардлагатай болсон. Олон бэрхшээлтэй тулгарсан хэдий ч 2020 онд бид хамтдаа мэрийн ажиллаж, үүрэг амлалтаа аюул осолгүй биелүүлж, өндөр бүтээмжтэй ажиллаж чадлаа.

Ялангуяа аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр хүрсэн ололт амжилтаараа бид бахархаж байна. Оюу толгой нь аюулгүй ажиллагаагаар салбартаа тэргүүлэгчийн хэмжээнд хүрснийг энэ жилийн гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт (AIFR) 0.15 байгаагаас харж болно.

Бид аюулгүй ажиллагааны үзүүлэлтээрээ дэлхийн бусад тэргүүлэх компаниудтай харьцуулагдах хэмжээнд, ахисан шатанд гарсан нь олон улсын жишигтэй харьцуулан үнэлдэг Аюулгүй ажиллагааны төлөв байдлын жилийн эцсийн үнэлгээгээр нотлогдлоо. Энэ нь бидэнд аюул ослыг тэглэх зорилгодоо хүрэхийн тулд аюул осолгүй ажиллах сэтгэлгээг төлөвшүүлэн, тогтолцоо, арга барилаа цаашид улам боловсронгуй болгон, сайжруулах урам зориг өгч байна. Монгол ажилтнуудаа удирдах албан тушаалд бэлтгэн, дэвшүүлэх бидний хүчин чармайлт, мөн аюул осолгүй ажиллах дадал, сэтгэлгээг компанийн үйл ажиллагааны бүх түвшинд төлөвшүүлснийг Үнэлгээний баг онцлон тэмдэглэсэн нь Оюу толгой компанийн онцгой давуу талыг батлан харууллаа.

Байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах тасралтгүй хүчин чармайлтын хүрээнд бид 2020 онд ус дахин ашиглалтын дундаж түвшнийг 80

хувьд хүргэх зорилтоо давуулан биелүүлж 87.7 хувьд хүргэлээ. Говь нутгийн хувьд ус чухал баялаг учраас ус дахин ашиглах үйл явцаа улам сайжруулан сацуу ус хэмнэх чиглэлээр орон нутагт үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлсээр байх болно.

КОВИД-19 цар тахлын нөлөөлөлтэй нүүр тулсан хэдий ч ил уурхай, гүний уурхайн төсөл, баяжуулах үйлдвэрийн багууд маань өндөр бүтээмжтэй ажиллалаа.

2020 онд цар тахлаас урьдчилан сэргийлэх хатуу арга хэмжээний үед баяжмалын тээвэрлэлтээ БНХАУ-ын хилээр зогсолтгүй нэвтрүүлж, зэс, алтны үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлэв.

Гүний уурхайн төслийн хувьд уурхайн шинэ зураг төслийг эцэслэн боловсруулж цаашдын хөгжил, тогтвортой үйлдвэрлэлд хүрэх үндэс суурийг тавилаа. Мөн Удирдлагын баг Гүний уурхайн төслийн багуудыг Үйл ажиллагааны хэсэг рүү амжилттай шилжүүлж гүний уурхайн үйлдвэрлэлийг эхлүүлэхэд итгэл төгс байгаагаа нотлон харууллаа.

Монгол Улсын эдийн засгийн чухал тулгуур баганын хувьд бид Монгол орны хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах үүрэг амлалтаа биелүүлэхийн төлөө тууштай ажилласаар байна. Бид бүс нутаг, орон нутгийн ард иргэдтэй сайн түншийн харилцаагаа улам бэхжүүлэн, үндэсний ханган нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлж, КОВИД-19 цар тахлын эдийн засгийн нөлөөллийг бууруулахад хувь нэмрээ оруулсаар байна. “Оюу толгой” компани 2010 оноос хойш нийт 11.6 тэрбум ам.долларыг дотоодод зарцуулсан байна. Энэ бол Монгол Улсад оруулсан гадаадын хамгийн том хөрөнгө оруулалт билээ.

Бид татвар, хураамж, үндэсний болон орон нутгийн худалдан авалт, цалин хөлс болон бусад шимтгэлд төлсөн төлбөрийн хэмжээгээр өнгөрсөн арван жилийн хугацаанд нийгэм, улс орны эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж ирлээ.

2020 онд Оюу толгой нь дэлхийн хэмжээнд зэсийн салбарын хариуцлагатай, тогтвортой үйлдвэрлэгчийг тодруулдаг “Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч” батламжийг гардан авсан анхны үйлдвэрлэгчдийн нэг боллоо. Оюу толгойн үйлдвэрлэсэн зэсийг НҮБ-н Тогтвортой Хөгжлийн Зорилгын хүрээнд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүлэмжийн хийн ялгаруулалт, хүний эрх, орон нутгийн хөгжил зэргийг багтаасан Байгаль орчин, Нийгэм, Засаглалын ангиллын 30 шалгуураар үнэлсний үндсэн дээр энэхүү батламжийг гардуулсан юм.

Эдгээр ололт амжилтад бид хамт олныхоо хичээл зүтгэлийн үр дүнд хүрсэн билээ. Хамт олон маань урьд өмнө нь тулгарч байгаагүй бэрх сорилттой шийдэмгий нүүр тулж, чин хичээл зүтгэл гарган, шаргуу ажиллалаа. Нийт баг хамт олныхоо онцгой хүчин чармайлтын ачаар цар тахлын улмаас өөрчлөгдөж буй тодорхойгүй нөхцөл байдлыг даван туулж, зэсийн баяжмалын цуваагаа тасалдуулалгүй, ажиллах хүчний ээлж солих ажлыг боломжит үед нь зохион байгуулж, хамт олныхоо эрүүл мэнд, сайн сайхан байдлыг ханган ажилласан юм.

2020 оны ололт амжилтаа дүгнэх энэ үед бид цаашдын сорилт бэрхшээл, боломжуудад бэлэн байх шаардлагатай болохыг өнгөрсөн он тод харууллаа. 2021 он бол гүний уурхайн бүтээн байгуулалтын чухал зорилтуудыг хэрэгжүүлэх, гүний уурхайн огтолгооны үйл ажиллагааг эхлүүлэн үйлдвэрлэл явуулах, мөн түүнчлэн эрчим хүчний

шийдлийг хангах чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллах чухал жил байх болно. Түүнчлэн зэс, алтны үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө зардлын тооцоололд нийцүүлэн биелүүлэх, орон нутгийн бизнес эрхлэлтийг хөгжүүлэн орон нутгийн иргэдтэйгээ тогтоосон түншлэлийн харилцаагаа бэхжүүлж, үндэсний хангамжийн сүлжээг өргөжүүлэн, хүний хөгжилд хөрөнгө оруулалт хийж, Оюу толгойн талаарх бодит мэдээллийг олон нийтэд хүргэх зэрэг чухал ажлууд бидний өмнө байна. Бид эдгээр зорилтоо чадварлаг хамт олныхоо хамтын хүчээр хэрэгжүүлж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Эцэст нь онцлон тэмдэглэхэд, сорилт бэрхшээл дүүрэн 2020 оны туршид бидэнд дэмжлэг үзүүлсэн хувьцаа эзэмшигчид, оролцогч талууд, орон нутаг, бүс нутгийн болон үндэсний түнш, ханган нийлүүлэгчид, гэрээт хамтрагч байгууллагууддаа чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье. 2021 онд хамтдаа илүү их амжилтад хүрнэ гэдэгт итгэл дүүрэн байна. Оюу толгойн амжилт, тогтвортой үйл ажиллагаа Монгол Улсын хувьд өнөөдөр урьд урьдынхаас илүү чухлаар тавигдаж байна. Иймд бид хамтдаа зогсолтгүй урагшлан, хөгжиж дэвжих учиртай билээ.

Армандо Торрес  
Гүйцэтгэх захирал

Жак Ван Тондер  
Гүний уурхайн төслийн захирал



# Компанийн тухай

**Оюу толгой нь Монгол Улсын Өмнөговь аймагт оршдог дэлхийн хэмжээний уурхай бөгөөд ээсийн агуулгаараа дэлхийд тэргүүлдэг ордуудын нэг.**

**“Оюу толгой” ХХК нь “Туркойз Хилл Ресурс” ХК (66 хувь) болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК (34 хувь)-ийн хувь нийлүүлсэн компани юм. Хувь нийлүүлэгч “Эрдэнэс Оюу толгой” ХХК нь Монгол Улсын төрийн өмчит компани. “Туркойз Хилл Ресурс” ХК-ийн дийлэнх буюу 51 хувийг “Рио Тинто” групп эзэмшдэг. “Рио Тинто” 2010 оноос хойш Оюу толгойн стратеги болон үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлж байна.**

**“Оюу толгой” уурхайн цогцолбор Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 километр, Монгол-Хятадын хилээс хойш 80 орчим километрт оршдог. Олон арван жилийн хайгуулын үр дүнд Оюу толгойн ордыг 2001 онд нээн илрүүлсэн түүхтэй.**

Уул уурхайн бизнесийн бүхий л чиглэлээр мэргэшсэн гүйцэтгэх удирдлагын баг “Оюу толгой” компанийг удирдан, стратегийн бодлогыг хэрэгжүүлдэг. “Оюу толгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигч талуудын төлөөллөөс бүрддэг бөгөөд компанийн стратегийн чиглэлийн дагуу шийдвэр гаргах, хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг.

2020 оны эцсийн байдлаар Оюу толгойн нийт ажиллах хүчний 95.4 хувь нь монгол ажилчид байсан бөгөөд тэдний 24.2 хувийг Өмнөговь аймгийн ажиллах хүчин бүрдүүлжээ.

“Бидний ажлын арга барил” хэмээх “Оюу толгой” компанийн бизнесийн ёс зүйн дүрмийг бид бизнесийн аливаа шийдвэр гаргахдаа мөн ажилтан бүр ажлаа гүйцэтгэхдээ мөрдлөг болгон ажилладаг. Энэхүү ёс зүйн дүрэмд байгаль орчны хамгаалал, тогтвортой хөгжил, авилгаас ангид байх, ажилчдын ёс зүй, эрх үүрэг тусгагдсан болно.

“Оюу толгой” компани үйлдвэрлэсэн зэс, алтны агуулгатай баяжмалаа спот болон урт хугацаатай хэлцэл байгуулан олон улсын зах зээлд борлуулдаг.

Уурхайн ашиглалтын хувьд ил уурхайгаас хүдэр олборлож, хоногт 100,000 тонн хүдэр баяжуулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр, дагалдах байгууламж, дэд бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Гүний уурхайн бүтээн байгуулалтын үйл явц амжилттай урагшилж байна. Гүний уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед “Оюу толгой” компани бага өртгөөр үйлдвэрлэл явуулдаг дэлхийд өрсөлдөхүйц томоохон ээсийн уурхайн нэг болох юм.

2020 онд “Оюу толгой” компани 10 жилийн хөгжлийн стратегийнхаа дагуу аюулгүй ажиллагаа, хамт олон, түншлэл, мөнгөн хөрөнгө, өсөлт гэсэн таван үндсэн чиглэлд төвлөрч ажиллалаа. Бид зах зээлийн үл тасрах сорилтуудыг даван туулахын сацуу дэлхийн хэмжээний уурхайн төслийг хэрэгжүүлэн, зах зээлийн тэргүүлэгч байр сууриа хадгалсаар байна.

# Алсын хараа, манай ирээдүй

Алсын хараа	Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ				
Эрхэм зорилго	Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц эзсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна				
Үнэт зүйлс	Аюулгүй ажиллагаа	Хамтын зүтгэл	Хүндэтгэл	Ёс зүй	Төгөлдөршил
Тэргүүлэх чиглэл					
Үндсэн зорилт	<p>Аюулгүй ажиллагаагаа улам бататгаж, салбартаа тэргүүлнэ</p> <p>Дэлхийн жишигт нийцсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаагаа хадгална</p>	<p>Чадварлаг, эвсэг хамт олныг бүрдүүлнэ</p> <p>Хөдөлмөр эрхлэх шударга, нээлттэй орчныг бэхжүүлнэ</p> <p>Авьяас, ур чадварыг үргэлжлүүлэн хөгжүүлнэ</p>	<p>Бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж, үр ашгаа нэмэгдүүлнэ</p> <p>Шинийг эрэлхийлсэн, эзний сэтгэлгээтэй, бүтээлч хамт олныг төлөвшүүлнэ</p>	<p>Хамтран ажиллагч талуудтай үр ашигтай, эерэг харилцаагаа бэхжүүлнэ</p> <p>Өмнөговийн бизнес эрхлэлт, орон нутгийн бие даасан, тогтвортой хөгжлийг дэмжинэ</p> <p>Өрсөлдөх чадвартай, үндэсний ханган нийлүүлэлтийн тогтвортой сүлжээг дэмжинэ</p>	<p>Гүний уурхайн бүтээн байгуулалтыг хугацаанд нь дуусган, бүрэн хүчин чадалд нь хүргэснээр Оюу толгойн ирээдүйг баталгаажуулна</p> <p>Түншийн тогтвортой харилцааг эрхэмлэн бэхжүүлнэ</p> <p>Бүтээгдэхүүнийг зах зээлд осол аюулгүй, түргэн шуурхай хүргэх чадавх бүхий ханган нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлнэ</p>

2020 оны туршид “Оюу толгой” ХХК “Алсын хараа - Манай ирээдүй” буюу компанийнхаа алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, тэргүүлэх чиглэлүүдийг удирдамж болгон ажиллалаа.

2015 оноос хойш нийт компанийн хэмжээнд мөрдөж буй энэхүү “Алсын хараа - Манай ирээдүй” нь биднийг аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц эзсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахыг гол зорилгоо болгон ажиллахад маань үндсэн чиг шугам болж байдаг.

Бид аюулгүй ажиллагаа, хамтын зүтгэл, хүндэтгэл, ёс зүй болон төгөлдөршил гэсэн таван үнэт зүйлсээ өдөр тутам тууштай эрхэмлэн ажилладаг. Эдгээр үнэт зүйлс маань бидний зан харилцаа, хандлага мөн бизнесийн хувьд биднийг хэн болохыг, юуны төлөө зорьж байгааг тодорхойлдог.

“Алсын хараа - Манай ирээдүй” нь манай бизнесийн тэргүүлэх таван чиглэлийг тодорхойлдог.

## Тэргүүлэх чиглэл



Аюулгүй ажиллагаа



Хамт олон



Мөнгөн хөрөнгө




Түншлэл



Өсөлт



A photograph of two construction workers in safety gear. The worker on the left is wearing a green hard hat and an orange high-visibility jacket, looking down at a small green and white object in his hands. The worker on the right is wearing a red and white hard hat and an orange high-visibility jacket, looking towards the first worker. They are standing in a dark, industrial setting with a concrete ceiling and some wooden beams visible in the background. The lighting is dramatic, highlighting the workers against the dark background.

**Эрдэс баялгаас  
ЭРДЭМ МЭДЛЭГ, ур  
чадвар, үнэт зүйлс  
бүтээлцэнэ**

# Санхүүгийн гүйцэтгэл

## Үнэ

Зэсийн үнэ 2020 оны гуравдугаар сард 1 тонн нь 4,617 ам.долларт хүрч, оны хамгийн доод түвшиндээ хүрсэн ч, эргээд 73 хувиар өсөж, оны эцэс гэхэд сүүлийн 7 жилийн хамгийн дээд түвшин буюу 1 тонн нь 7,964 ам.долларт хүрсэн юм. Оны нэгдүгээр улиралд зэсийн үнэ КОВИД-19 цар тахлын улмаас огцом унасан боловч, БНХАУ-ын зэсийн эрэлт жилийн сүүлийн хагаст хурдацтай сэргэснээр зэсийн хэрэглээ тооцоолж байснаас давж, дэлхийн бусад улсад зэсийн хэрэглээ буурснаас үүдэх алдагдлыг нөхсөн. Эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээг дэлхийн улс орнууд хоорондоо харилцан уялдаатай авч, металлын орц өндөртэй дэд бүтэц, ногоон хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, улмаар зэсийн үнэ дөрөвдүгээр улирлаас эхлэн огцом өссөн. Алтны үнэ цар тахлын нөлөөгөөр мөн адил нэмэгдэж, оны дундаж үнэ 1 унц нь 1,770 ам.долларт хүрсэн нь өмнөх оныхоос 27 хувиар өссөн үзүүлэлт юм. Хөрөнгө оруулагчид 2020 оны хоёр болон гуравдугаар улирлын ихэнхэд эрсдэлгүй хөрөнгө оруулалт гэж үзэн алт руу хошуурснаар үнэ нь наймдугаар сард хамгийн дээд түвшиндээ буюу 1 унц нь 2,000 ам.долларт хүрсэн. Оны дунд үеэс эхлэн засгийн газрууд эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээ авч эхэлснээр дэлхий даяар хөрөнгийн зах зээл сэргэж, алтны үнэ эргээд буурсан.

## Орлого

Борлуулалтын орлого 2019 оныхоос буурсан нь агуулга багатай хүдэр боловсруулж, алтны агуулга багатай баяжмал үйлдвэрлэсэнтэй холбоотой. Түүхий эдийн үнэ өндөр байсан нь борлуулалтын хэмжээ багассанаас үүдсэн нөлөөллийн зарим хэсгийг нөхөж чадсан.

2020 онд "Оюу толгой" компани 138 мянган тонн зэс (2019 онд 150 мянган тонн), 150 мянган унц алт (2019 онд 274 мянган унц), 760 мянган унц мөнгө (2019 онд 896 мянган унц) тус тус агуулсан 670 мянган тонн баяжмал (2019 онд 725 мянган тонн) борлуулж, 1 тэрбум 78 сая ам.долларын (2019 онд 1 тэрбум 166 сая ам.доллар)-ын орлого олсон.

## Үйлдвэрлэл

Ил уурхайн нийт олборлосон материал 2019 онд 101.3 сая тонн байсан бол 2020 онд 97.7 сая тонн болж буурсан. Энэ нь ил уурхайн олборлолтын илүү гүнзгий хэсэг болох 4В, 6В үе шатууд руу шилжиж, ачаа эргэлтийн хугацаа ихэссэнтэй холбоотой. Боловсруулсан хүдрийн хэмжээ 1 хувиар буурч 40.2 сая тонн болсон нь тээрмийн бэлэн байдал ялимгүй буурснаас үүдэлтэй.

Сая ам.доллар	2020	2019	2018	2017	2016
Борлуулалтын орлого	1,078	1,166	1,180	940	1,203
Үндсэн үйл ажиллагааны, Татвар, хүү, элэгдлийн өмнөх ашиг*	379	350	367	230	390
Үндсэн үйл ажиллагааны, Татвар, хүү, элэгдлийн өмнөх ашгийн хувь (%)*	35%	30%	29%	24%	32%
Урсгал капиталын зардал	58	134	91	82	101
Гүний уурхайн капитал зардал	1,010	1,194	1,234	852	230
Улсад төлсөн татвар, шимтгэл, бусад төлбөр**	200	209	200	180	190

\* Орлогын татвар, Хүүгийн зардал, Элэгдэл, Хорогдлыг тооцохын өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг нь орлогын тайланд тусгагдсан орлогын татвар, санхүүгийн цэвэр зардал, элэгдэл, хорогдлын зардлыг тооцохын өмнөх ашгийг харуулах ба энэ дүн нь үнэ цэнийн бууралтын ямар нэгэн нөлөөг агуулаагүй болно.

\*\* НӨАТ ороогүй дүн. "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.



## Урсгал капиталын зардал

Урсгал капиталын зардал 2019 оныхоос 76 сая ам.доллаароор буурсан нь ил уурхайн олборлолтод 4В үе шатыг чухалчилж олборлосноор хоосон чулуулгийн тээвэрлэлт багасаж, хойшлуулсан хөрс хуулалтын капитал зардал 43 сая ам.доллаароор, урсгал капиталын төслийн зардал 26 сая ам.доллаароор, гол эд ангиудын засвар, үйлчилгээний хуваариас үүдсэн зардал 8 сая ам.доллаароор тус тус буурснаас голлон шалтгаалав.

## Гүний уурхайн капитал зардал

2020 онд гүний уурхайн бүтээн байгуулалтын капитал зардал 1 тэрбум 10 сая ам.доллар буюу 2019 оныхоос 184 сая ам.доллаароор бага байгаа нь КОВИД-19 цар тахлын улмаас гадаад мэргэжилтнүүдийн ээлж солилцох хөдөлгөөнд хязгаарлалт тавигдсантай холбоотой.

2016 оны нэгдүгээр сараас хойш тайлангийн хугацаанд гүний уурхайн төсөлтэй холбоотой гарсан нийт зардал 4.5 тэрбум ам.долларт хүрээд байна. Төслийн хүрээнд байгуулсан нийт гэрээ хэлцлийн дүн 5 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнээс 3.7 тэрбум ам.долларын гэрээ хэлцлийг дотоодын ханган нийлүүлэгчидтэй байгуулснаар 2016 онд анх тавьсан 1.4 тэрбум ам.доллар, 2018 онд шинээр тавьсан 2.0 тэрбум ам.долларын зорилтыг давуулан биелүүллээ. Шууд гэрээний дүнгээр нийт 1.0 тэрбум ам.доллар олон улсын ханган нийлүүлэгчдэд олгогдсон байна. Худалдан авах ажиллагаа, гэрээний багцуудаар дамжуулан дотоодын ханган нийлүүлэгчдэд зарцуулсан дүн нь Төслийн худалдан авах ажиллагааны нийт дүнгийн 78 хувийг эзэлж байна.

## Татвар, шимтгэл, бусад төлбөр

2020 онд Монгол Улсын Засгийн газарт татвар, шимтгэл, бусад төлбөрт 200 сая ам.доллар төлсөн нь 2019 оныхоос 9 сая ам.доллаароор бага байна. Энэ нь КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ багассаны улмаас суутгах татвар 6 сая ам.доллаароор (2020 онд 8 сая ам.доллар, 2018 онд 14 сая ам.доллар), гадаад мэргэжилтний тоо буурсантай холбоотойгоор нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт 4 сая ам.доллаароор тус тус буурсантай холбоотой.

Гүний уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, төслийн санхүүжилтийн зээлийн хүү, үндсэн зээлийг төлөх зорилгоор 2020 онд 982 сая ам.долларын (2019 онд 1 тэрбум 375 сая ам.доллар) санхүүжилт татсан. Санхүүжилтийн 405 сая ам.долларыг (2019 онд 645 сая ам.доллар) энгийн хувьцаа, 577 сая ам.долларыг (2019 онд 730 сая ам.доллар) хувьцаа эзэмшигчдийн зээл хэлбэрээр татсан. 2019 онд гаднаас авсан санхүүжилт төлөвлөсөн хэмжээнээс бага байсан нь үйл ажиллагаанаас орсон орлого нь тухайн үйл ажиллагааны урсгал капиталын зардлаас давсантай холбоотой. Оны эцэст нийт зээлийн хэмжээ 11.45 тэрбум ам.доллар байв.



# Зохистой зарцуулалтын арга хэмжээ

Тус компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Бизнес шинэчлэлтийн хөтөлбөр” нь байгууллагадаа эзний ёсоор хандах соёлыг төлөвшүүлэх замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлох, түүнийг нэмэгдүүлэх, мөн компанийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулахад чиглэдэг. Тус хөтөлбөр нь анх 2017 онд хэрэгжиж эхэлсэн ба үүнээс хойш орлого нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардал бууруулах, ажлын цэвэр капитал болон капиталын урсгал зардал хэмнэх зэрэг Зохистой зарцуулалтын арга хэмжээ хэрэгжүүлснээр 1 тэрбум ам.долларын<sup>1,2</sup> үр өгөөжийг өгөөд байна.


“Бизнесийн нийт боломжийг бүрэн дайчлах”, “Шинэ санаа гаргах” семинаруудыг зохион байгуулснаар дорвитой сайжруулах арга зам, санаа, санаачилгыг тодорхойлж, бизнес шинэчлэлийн хөтөлбөрийн мэдээллийн сан бүрдүүлэн “Моментум” системд эдгээр санаа, санаачилгыг бүртгэж, явцыг тайлагнадаг. Санаачилга дэвшүүлсэн ажилчдын хүчин чармайлт, хөдөлмөрийн үр дүнд бид 2020 онд 407 сая ам.долларын<sup>2</sup> хэмнэлт бүрдүүлсэн нь тус оны 249 сая ам.долларын зорилтыг давж биелүүллээ.

2020 оны зарим гол амжилт:

- » “Бизнес шинэчлэлтийн хөтөлбөр” нь эзний сэтгэлгээг төлөвшүүлэх, асуудал шийдвэрлэх ур чадварыг эзэмшүүлэх үйл явцыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байна,
- » Хөтөлбөрийн үйл явцын нарийвчлал боловсронгуй болсоор байна,
- » Оролцогчдын идэвх өндөр, хамтын ажиллагаа нягт,
- » Нийт 165 хүний санаачилж дэвшүүлсэн 362 төсөл төслийн боловсруулалтын үйл ажиллагааг удирдан зохион байгууллаа,
- » 150 оролцогчтой “Шинэ санаа гаргах” семинарыг 19 удаа зохион байгуулсан,
- » Хэлтэс тус бүрийн өдөр ба долоон хоног тутмын зардлыг хянах явцад түлхүү анхаарсны дүнд компанийн зардал мэдэгдэхүйц буурч байна.

## 2020 оны “Бизнес шинэчлэл”-ийн хөтөлбөрийн үр дүн

(сая ам.доллар)



1 Мөнгөн үнэлэмж нь 2017-2020 онуудын хуримтлагдсан дүнгээр болно.

2 Бизнес шинэчлэлтийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа сайжруулалтыг хэмжихдээ өмнөх жилийн үзүүлэлттэй харьцуулах ба үнэ гэх мэт гадаад нөлөөлөл, хүчин зүйлсийг тооцдоггүй болно. Хэдийгээр санхүү, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тооцолж байгаа ч, эдгээр мөнгөн дүн нь бизнесийн санхүүгийн гүйцэтгэлийг илэрхийлэхгүй болно

# Ханган нийлүүлэлтийн сүлжээ

“Оюу толгой” компани нь найдвартай ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгох замаар үйл ажиллагааныхаа тасралтгүй байдлыг ханган, аль болох илүү үр өгөөж авчрахын зэрэгцээ улсын хэмжээнд, тэр дундаа Өмнөговь аймагт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгож, дотоодын ханган нийлүүлэлтийг хөгжүүлэхээр зорьж байна.


Үйл ажиллагааны нийт худалдан авалт дахь дотоодоос авсан худалдан авалтын эзлэх хувь хэмжээ тасралтгүй нэмэгдэж, 2020 онд 85 хувьд хүрсэн байна. 2020 онд нийт 770 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 499 нь үндэсний ханган нийлүүлэгч байв. 2010 - 2020 онд үндэсний худалдан авалтад нийт 3.54 тэрбум ам.доллар зарцуулсан байна. Өмнөговь аймгаас худалдан авалт жил бүр нэмэгдсээр 2010 онд 0.5 сая ам.доллар байсан бол 2020 онд 120 сая ам.долларт хүрлээ.

2020 онд үйл ажиллагаагаа аюул осолгүй явуулахад нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, гэрээт ажилтнуудын шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад КОВИД-19 цар тахлын улмаас хүндрэлтэй байлаа. Үндэсний худалдан авалтыг дэмжих “Монголд үйлдвэрлэв” хөтөлбөрийн хэрэгжилтийн ачаар уурхайд нэн чухал олон бараа бүтээгдэхүүнийг илүү ойроос ханган нийлүүлэх боломж бүрдсэн нь цар тахлын үед үйл ажиллагаагаа явуулахад чухал ач холбогдолтой байлаа.

## Үндэсний худалдан авалт


(2010 - 2020, сая ам.доллар)

Өсөн нэмэгдсэн дүнгээр **3.54** тэрбум ам.доллар



## Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалт

(2010 - 2020, сая ам.доллар)



## “Монголд үйлдвэрлэв” хөтөлбөр

“Монголд үйлдвэрлэв” хөтөлбөр улам өргөжин гар ариутгагч, чийгтэй ариутгагч салфетка, гал унтраагуур, үйлдвэрлэлийн хэрэгцээний агаар шүүлтүүр, төрөл бүрийн цахилгаан бүтээгдэхүүн зэрэг нь импортлодог байсан олон бараа, бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчээс худалдаж аван хүрээгээ тэлсээр байна. Жилийн 9.7 сая ам.долларын өртөг бүхий 11 шинэ “Монголд үйлдвэрлэв” гэрээ 2020 онд байгуулснаар 320 гаруй ажлын байр бий болгов.



Уг хөтөлбөр нь хурдацтай явагдаж буй гүний уурхайн бүтээн байгуулалттай уялдаж, байнга хэрэглэгдэх бараагаар нэр төрлөө нэмж байна. Тухайлбал, бэхэлгээний болт болон бэхэлгээний цавууг Ханбогд суманд угсардаг болж, улмаар уурхайн ашиглалтын туршид шаардагдах үйлдвэрлэл, ур чадварыг орон нутагт бий болгоод байна.

## Ханган нийлүүлэгчдийг чадавхжуулах хөтөлбөр

Ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх хэрэгцээ нэмэгдсэнээр уг хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Даланзадгад дахь Бизнес инновацийн хөгжлийн төвүүдээр дамжуулан 5S, Кайзен зэрэг үйлдвэрлэлийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээс гадна, бизнес төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлсээр байна.

2018 онд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 441 сургалт\*, арга хэмжээ зохион байгуулж, 3,521 оролцогч (58% нь эмэгтэйчүүд) хамрагдсанаас оролцогч бизнес эрхлэгчдийн 72% нь бизнесээ өргөжүүлж, 34% нь орлогоо нэмэгдүүлж, 3.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкуудаас авсан үр дүнтэй байна.




## Ханган нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт



“Оюу толгой” компани нь Монголын томоохон таван арилжааны банкттай байгуулсан гэрээг шинэчлэн, “Ханган нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэхээр боллоо. Энэхүү хөтөлбөр нь ханган нийлүүлэгчдэд хямд өртөг бүхий санхүүжилтийг таатай нөхцөлөөр авах боломжийг олгодог. Ингэснээр Оюу толгойн ханган нийлүүлэлтийн сүлжээг найдвартай болгохын зэрэгцээ дотоодын бизнес эрхлэгчдэд мөнгөн урсгалаа удирдахад нь дэмжлэг үзүүлдэг юм.

2020 оны эцсийн байдлаар 300 орчим ханган нийлүүлэгч уг хөтөлбөрөөр дамжуулан 600 сая ам.доллар буюу 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт авсан байна.

\* Бизнесийн инновац хөгжлийн төвийн дотоод үнэлгээ. “Оюу толгой” компани нь дотоодын арилжааны банкуудтай хамтран ханган нийлүүлэгчдэд бага хүүтэй, тааламжтай нөхцөлтэй эзэлийн бүтээгдэхүүнийг хүргэх зорилгоор ханган нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн хөтөлбөрийг гурван жилийн өмнөөс хэрэгжүүлж эхэлсэн.



# Аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд болон байгаль орчин

Аюулгүй ажиллагааг ханган, байгаль орчныг хамгаалах нь бидний хувьд 2020 онд эн тэргүүний зорилт хэвээр байлаа. КОВИД-19 цар тахлаас үүдэн шинэ сорилт бэрхшээлтэй тулгарснаар ЭМААБО-ны баг аюулгүй ажиллагааны гүйцэтгэлд онцгой анхаарч, шинэ стандарт тогтоож чадсан.

Аюулгүй ажиллагааны үндсэн тулгуур болох дараах хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлсээр байна. Үүнд:

- » Амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх – Ноцтой эрсдэлийн удирдлага (НЭУ),
- » Гамшгаас урьдчилан сэргийлэх - Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны менежмент (ҮААМ),
- » Бэртэл гэмтлийг бууруулах.

2020 оны эцсийн байдлаар 200,000 хүн/цагт ногдох Бүх гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт (БГДҮ) 0.15 байсан нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагаагаар тэргүүлэх уурхайнуудын нэг болж байна.

## 2020 оны зарим амжилт:

- » “Оюу толгой” компани НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлсэн зэс үйлдвэрлэлийн салбарын шилдэг туршлагуудыг таниулах зорилготой итгэмжлэгдсэн, цогц хяналт, баталгаажуулалтын “Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч” батламжаар шагнуулсан юм,
- » Оюу толгойн удирдах ажилтнууд ажлын байрны эрсдэлийг арилгах 181,000 гаруй магадалгаа хийсэн. Бид аюулгүй ажиллагааны стратегийн гурван гол зарчмыг жигд хангахад чиглэсэн Аюулгүй ажиллагааны хөгжлийн загвар (ААХЗ)-ыг амжилттай нутагшуулан хэрэгжүүлээ. Ингэснээр аюулгүй ажиллагааны гүйцэтгэлээ группийн хэмжээнд харьцуулан үнэлэх юм,
- » Аюулгүй ажиллагааны хандлага, үр дүнг сайжруулж, улмаар удирдах ажилтан ба баг хоорондын харилцааг идэвхжүүлэн, Аюулгүй ажиллагааны төлөвшлийн загварын нэгэн хэсэг болох аюулгүй ажиллагааны манлайлын ур чадварыг ажилчдадаа тасралтгүй хөгжүүлэх зорилгоор “Аюулгүй ажиллагааны коучинг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн,
- » “Оюу толгой” компани ноцтой осол зөрчил гарснаас хойш 12-18 сарын дараа тухайн осол зөрчилд Ахлах удирдлагын багаас “гурав дараалсан хяналт, шалгалт” явуулах үйл явцыг хэрэгжүүлж эхлээд байна. Ингэснээр тухайн ноцтой осол зөрчлийг дахин давтагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй хяналтын арга хэмжээний үр дүнтэй байдлыг үнэлэх юм,
- » Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны томоохон хор аюулын эрсдэлийн менежмент нь 2020 онд голлон анхаарсан ажлуудын нэг байлаа. “Оюу толгой” компани үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гамшгийн хэмжээний ослоос урьдчилан сэргийлэх “Томоохон хор аюулын тогтолцоо”-г хэрэгжүүлж байна.

## Байгаль орчин

“Оюу толгой” компани байгаль орчны сөрөг нөлөөлмөөс сэргийлэх, бууруулах, нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төслүүдийг хэрэгжүүлэх замаар сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд хүргэж, байгаль орчны хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллийг дэмжих зорилгоор “Оюу толгой” компани 2020 онд дараах байгаль орчны баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулсан:

- » Хариуцлагатай үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг ханган, “Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч” батламжаар шагнуулсан,
- » Төслийн санхүүжилтийн гэрээний дагуу Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн аудит.

## Ус



Гүний ус нь говь нутгийн чухал баялаг учраас түүнийг дээд зэргээр ариг гамтай ашиглахыг зорьдог. 2020 онд Оюу толгой ус ашиглалтыг хамгийн доод хэмжээнд байлгаж чадсанаар уул уурхайн салбартаа тэргүүлж байна. Нэг тонн хүдэр боловсруулахдаа 0.4 м/кубээс бага ус ашиглаж, ус дахин ашиглалтын түвшнийг нэмэгдүүлж, дунджаар 87.7 хувьд хүргэлээ.

Оюу толгой усны хайгуулын хуучин цооног битүүмжлэх төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 2020 онд нийт 32 цооногийг битүүмжлэн, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгсөн.

## Биологийн олон янз байдал



Биологийн үндсэн олон янз байдлын мониторингийн хөтөлбөрөөр Монгол орны өвөрмөц ургамал, амьтны аймгийг хамгаалах цуврал санаачилгыг хэрэгжүүлээ. Хар сүүлт зээрт хүзүүвч зүүх төслөөр 28 хүзүүвч амжилттай зүүснээр энэхүү амьтны төрөл зүйлийг хамгаалахад хөгжлийн төслүүдийн ач холбогдлыг таниулахад чухал үүрэгтэй байлаа. Ижил төрлийн тооллого хийх мониторингийн төслийг аргаль, шувууд, хулан мөн бусад төрөл зүйлийг хамгаалах чиглэлд хэрэгжүүлж дуусгасан.

Оюу толгой бүс нутгийн хэмжээнд ховордоод буй торой модыг хамгаалахад орон нутгийн төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэн, бэлчээрийн талхалтаас хамгаалах зорилгоор хашлага барьсан. Улмаар залуу модны ургалт сэргэж эерэг үр дүн даруй гарсан.

## Нөхөн сэргээлт



2020 оны гол амжилтын нэг нь нөхөн сэргээлтийн улсын шалгуурыг хангасан бэлчээрийг орон нутгийн захиргаанд амжилттай хүлээлгэн өгсөн явдал юм. Нийт 52 га талбайг олон жилийн нөр их хүчин чармайлтын үр дүнд нөхөн сэргээсэн ба орон нутгийн шалгалтын баг бүрэлдэхүүн уг талбайг бүрэн нөхөн сэргээгдсэн болохыг баталгаажуулсан. Мөн түүнчлэн Оюу толгойн зүгээс 15.7 га газарт техникийн, 19 га газарт биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 2020 онд хийж гүйцэтгэлээ.



## “Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч” батламж

Зэсийн салбарын хариуцлагатай үйлдвэрлэгчийг тодруулдаг “Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч” батламжаар “Оюу толгой” компани шагнууллаа.

“Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч”-ийн батламжийн болзлыг хангахын тулд хариуцлагатай, ил тод үйл ажиллагаа явуулдаг гэдгээ нотлон 30 гаруй шалгуур үзүүлэлтийг хангасан.

“Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч” буюу “The Copper Mark” батламж нь зэсийн салбарын хариуцлагатай үйлдвэрлэлийг тодруулдаг анхны бөгөөд өдгөө байгаа цор ганц хөтөлбөр юм. Олон Улсын Зэсийн Холбооноос харилцагчид, ТББ, зэс үйлдвэрлэгчдийн саналыг тусган анх санаачилж байсан уг хөтөлбөр нь олон талт зөвлөлтэй, бие даасан байгууллага болон өргөжин ажиллаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд “Оюу толгой” компани үйл ажиллагаандаа баримтлах зарчим, нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр болон байгаль орчны нөлөөллийг хэрхэн удирдан хянаж байгаатай холбоотой олон амлалт, үүргийг хүлээсэн байдаг. Монгол Улсын урт хугацааны хөгжил, тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээг дэмжихэд “Оюу толгой” чухал үүрэг хүлээж байгаа гэдгийг тодотгож өгдөг бодлого, журам, арга барилуудад эдгээр үүрэг амлалт тусгалаа хэдийн олсон байна.





# Аюулгүй байдал ба ГЭНЭТИЙН АЮУЛД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

## Гүний уурхайн аврах ажиллагаа

### Гүний уурхайн аврах ажиллагааны сургалт

Гүний уурхайн аврах баг 6,368 хүн/цагийн сургалтыг 156 сайн дурын аврагчдад аюул осолгүйгээр зохион байгууллаа. Тухайлбал уурхайн аврах ажиллагааны үндсэн ур чадварын сургалт, уурхайн аврах багийн давтан сургалт, анхны тусламжийн багийн галын аюулгүй байдлын сургалтад хамруулав.

### Гүний уурхайн аврах ажиллагааны байгууламж

Гүний уурхайн 1,256 метрийн түвшинд энэхүү байгууламжийг хүлээлгэн өгснөөр аврах ажиллагаанд шаардлагатай бүхий л багаж, тоног төхөөрөмжийг бэлэн байлгаж, онцгой байдлын үед цаг алдалгүй хариу арга хэмжээ авах боломжтой болох юм. Тус байгууламж нийт 50 хүний багтаамжтай, гадаргуу дээрээс уурхайн шахсан агаар, цахилгаан эрчим хүчээр хангах шаардлагагүйгээр 72 цагийн турш бие даан ажиллах чадвартай. Түүнчлэн ослын нөхцөл байдал урт хугацаанд үргэлжлэх тохиолдолд үед хэд хэдэн аврах багийг багаж, нөөцөөр хангах хүчин чадалтай. Тус аврах байгууламж нь ашиглахад бэлэн болоод байна.

### Аврах ажиллагааны тээврийн хэрэгсэл MRV 9000

Бид аврах ажиллагааны "Draeger MRV 9000" тээврийн хэрэгслийг 2020 оны эхний улиралд хүлээн авч, ашиглалтад оруулсан. Энэхүү тээврийн хэрэгсэл нь аврах багийн гишүүдийг зорчих явцад гүний уурхайд агаар дутагдах нөхцөлд аврах "ССВА" амьсгалын аппарат шаардахгүйгээр дор хаяж 5 цагийн турш амьсгалах агаараар хангаж чадна. Мөн үзэгдэх орчин хязгаарлагдмал, гүний уурхайн нөхцөлд дулааны камер ашиглах боломжтой.

Энэхүү тоног төхөөрөмж нь аврах багийн аюулгүй байдлыг хангахаас гадна гэнэтийн ослын үед гэмтсэн хүнийг гаргаж авахад чухал үүрэгтэй. Тус машинаар ослын газарт түргэн нэвтрэх боломжтой.


### Гадарга дээрх гэнэтийн ослын үеийн хариу арга хэмжээ:

Орон нутагт дараах гэнэтийн ослын үед дэмжлэг үзүүлэв:

- » Галын дуудлага - 2,
- » Зам тээврийн ослын дуудлага - 4.

Хамтрагч байгууллагуудтай зохион байгуулсан арга хэмжээ:

- » Өмнөговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн галын байцаагчтай хамтран Оюу толгойн уурхайн цогцолборт гал түймрээс урьдчилан сэргийлэх хоёр удаагийн үзлэг шалгалт явуулж, ослын сургамжаас арга хэмжээ авахад холбогдох багуудад дэмжлэг үзүүлсэн,
- » Ханбогд сумын гал түймэр унтраах бб-р анги хамтран гал сөнөөгчид, аврах багийн гишүүдэд гэнэтийн үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авахад бэлтгэх зорилгоор сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтын хөтөлбөр нь мэдлэг хуваалцаж, ур чадварт сургах зорилготой,
- » Оюу толгойн Аюулгүй байдлын хэлтсээс "Ханбогд Хурд" ХХК, "Бамбай Секьюрити" ХХК, "Империал Секьюрити" ХХК, Ханбогд сумын гал унтраах бб-р анги, Ханбогд сумын цагдаагийн албатай хамтран зам тээврийн ослын аврах ажиллагаа, гал унтраах дадлага сургуулилтыг зохион байгуулсан.





# ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХҮЙЦ ҮЙЛДВЭРЛЭЛ

**Оюу толгойн ил уурхайн үйл ажиллагаа КОВИД-19 цар тахлын бэрх сорилтуудтай нүүр тулсан хэдий ч, жилийн гүйцэтгэл дахин өндөр үзүүлэлттэй байв.**

## Ил уурхай


Уурхайгаас зөөвөрлөсөн уулын цулын хэмжээ 2019 онд 101 сая тонн байсан нь 2020 онд 98 сая тонн болж буурсан. Уурхайн үйл ажиллагаа олборлолтын 4В үе шатны ажлыг эрчимтэй урагшлуулахад төвлөрлөө. Олборлолтын 5А үе шат дээр хөрс хуулалтын урьдчилсан ажлыг эхлүүлж, 6В үе шат дээр олборлолт үргэлжлэн явагдсан. Ил уурхайгаас гарсан хоосон чулуулгийг Хаягдал хадгалах байгууламж нэгдүгээр үүрийн (ХХБ1) далангийн бүтээн байгуулалтад үргэлжлүүлэн ашиглалаа. Баяжуулах үйлдвэрийн тээрмийг тэжээсэн хүдрийн хэмжээ 2019 онтой харьцуулахад 1 хувиар буурсан нь 2020 онд тээрмийн завсар үйлчилгээний хоёр түр зогсолт хийсэн, голчлон уурхайн баруун өмнөд хэсгээс татсан хүдрийн хатуулаг нэмэгдсэн зэрэгтэй холбоотой. Ил уурхайн уулын ажлын төлөвлөгөөг эрчимжүүлж, олборлолтыг үечлэн явуулснаар агуулга сайтай хэсэг рүү шилжсэн тул ил уурхайгаас олборлосон зэсийн хэмжээ 2019 онтой харьцуулахад хоёр хувиар өссөн байна. Олборлолтыг үечлэн явуулснаар дөрөвдүгээр улиралд өмнөх улирлаас +139 хувиар илүү алт олборлосон байна. Зэс, алтны агуулга сайтай хэсгийн олборлолт 2021 оны турш үргэлжлэх төлөвтэй байна. КОВИД-19-ээс урьдчилан сэргийлэх заавар журмыг чанд мөрдөн баяжмалаа Хятад улсын хилээр үргэлжлүүлэн тээвэрлэж байна.

## Баяжуулах үйлдвэр

Өнгөрсөн онд 40.2 сая тонн хүдэр боловсруулсан нь үйлдвэрлэл эхэлснээс хойш гурав дахь хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Тайлант хугацаанд 670 мянган тонн баяжмал савлаж, олон улсын зах зээлд нийлүүлсэн бөгөөд 2020 оны турш үйлдвэрлэсэн баяжмалд агуулагдах зэс 150 мянган тонн, алт 182 мянган унци хүрчээ.


### Ил уурхайн нийт олборлосон материал

(сая тонн)



### Баяжуулах үйлдвэрийн нийт боловсруулсан хүдэр

(сая тонн)



# Мэргэшсэн ажиллах хүчин

Ямар ч хүнд бэрх цаг үед “Хамт олон”, “Өсөлт” бол бидний тэргүүлэх чиглэл байдаг. Бид өмнөх ололт амжилтаа ахиулахын төлөө хамт олонтойгоо хамт өсөж, хөгжихийг эрмэлзэн ажилладаг билээ. 2020 оны эцсийн байдлаар “Оюу толгой” компанийн нийт ажилтны тоо 12,364 байснаас ихэнх хувийг буюу 95.4 хувийг монголчууд бүрдүүлж байна.

Ажиллах хүчний чиглэлээр 2020 онд дэвшүүлсэн гол зорилтууд:

- » Ажилтнуудын эрүүл амьдралын хэв маягийг дэмжих,
- » Манлайллын хөтөлбөрийг өргөжүүлэх,
- » “ОТ Бидний бахархал” амжилт сайшаах хөтөлбөрийг өргөжүүлэх,
- » Ажилчдад үзүүлэх үйлчилгээг тасралтгүй сайжруулах,
- » Багуудыг нэг бүтэц, зохион байгуулалт дор нэгтгэх,
- » Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх.

## Ажилтнуудын эрүүл амьдралын хэв маягийг дэмжих

2020 он бол КОВИД-19-ийн цар тахалтай холбоотойгоор Улсын онцгой комисс, Оюу толгойн Бизнесийн бэлэн байдлыг хангах багаас гаргасан шийдвэр, чиглэл болон Рио Тинто группийн бодлоготой уялдуулан ажлын уян хатан зохицуулалтыг цаг тухайд нь хэрэгжүүлж ажиллах шаардлага үүссэн жил байлаа.

Бид богино болон урт хугацаанд бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс ажилчдадаа шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал, нэмэгдэл олговор, цалин хөлс, ажил амралтын хуваарь болон алжаал ядаргаа, амралтын зохицуулалттай холбоотой бодлого журмыг боловсруулж, ажилчдад дэмжлэг үзүүлсэн. Эдгээр зохицуулалт нь дэлхийг хамарсан цар тахлын тааварлашгүй эрсдэлтэй цаг үед ажилчдынхаа аюулгүй байдал, эрүүл амьдралын хэв маягийг дэмжихэд чиглэсэн хүн төвтэй байж, тэдэнд анхаарал халамж, дэмжлэг үзүүлэх зорилготой. “Оюу толгой” ХХК-ийн Хүний нөөцийн судалгааны 2020 оны дөрөвдүгээр улирлын үр дүнгээс харахад оролцогчдын 86% нь Оюу толгойн КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үр дүнтэй гэж дүгнэн, өндөр үнэлгээ өгсөн байна.

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЕД АВЧ БОЛОХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

**“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИЙН ЗҮГЭЭС ҮЭҮҮДЭГ ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ**

- АЖИЛТАНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ХАТГААР**
  - » 10211442 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
- ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГДЭГ БУСАД БАГУУ ИЛЛАГА**
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
- ЦАГДААГИЙН БАЙГУУЛАГА, ЛОК ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
- ХУУДАГИЙН ТУСЛАМЖ - ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЕД**
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
- ХУУДАГИЙН ТУСЛАМЖ - ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЕД**
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
- СЭТГЭЛИЙН ЗЭГЭЭЛ МЭНДИЙН ТҮНДСНИЙ ТОО**
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
- МЭНДИЙН ТУСЛАМЖ - ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮЕД**
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ
  - » 10210471 Сэтгэл зогсонгийн өвч, тусламж үзүүлэх үйлчилгээний үйлчилгээний үйлчилгээ

“Оюу толгой” компани “**Гэр бүлийн хүчирхийллийн талаарх зааварчилгаа**”-г боловсруулж, 2020 онд нийт ажилчдадаа танилцууллаа.

Энэхүү зааварчилгаагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсвэл өртөж болзошгүй тохиолдолд компаниас ямар дэмжлэг тусламж авч болох талаар удирдах ажилтан болон ажилтнууддаа цэгцтэй мэдээллийг өгсөн юм.

“Гэр бүлийн хүчирхийллийн талаарх зааварчилгаа”-ны дагуу “Оюу толгой” компанийн зүгээс ажилчдадаа дараах дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:

- » Чөлөө олгох (10 хүртэл өдрийн цалинтай чөлөө)
- » Ажлын уян хатан зохицуулалт
- » Ажлын байрыг хэвээр хадгалах
- » Онцгой тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- » “Ажилтанд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд сэтгэл зүйчийн зөвлөгөө эсвэл
- » Уурхайн цогцолбор дахь эмнэлэгт сэтгэл заслын тусламж зөвлөгөө авах



- » Машины зогсоолд хүргэж өгөх/тосох,
- » Утасны шинэ дугаар авахад нь туслах,
- » Утасны дуудлага, цахим шууданг нь шүүж өгөх/хааж блоклох,
- » Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг зохих, үйлчилгээнд холбон зуучлах.

“Оюу толгой” компани энэхүү журмыг баталж хэрэгжүүлэхийн сацуу гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газар болон Өмнөговь аймагтай хамтран “Гэр бүлийн үнэ цэнийг хүндэтгэе” аяныг 2020 онд зохион байгуулсан. Уг аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн талаарх багц мэдээллийг бэлтгэж нийт ажилтнууддаа түгээж танилцууллаа. Эдгээрээс заримыг дурдвал:

- » Удирдах ажилтнуудад зориулсан зөвлөмж,
- » Гэр бүлийн хүчирхийллийн үед авч болох тусламж үйлчилгээ,
- » “Ажилтны дуу хоолой” видео нэвтрүүлэг,
- » Богино хэмжээний видео мэдээлэл,
- » “Гэр бүлийн эерэг харилцааг бий болгох нь” сэдэвт зайн сургалт,
- » Гэр бүлийн хүчирхийллийн талаар ажилчдад зориулсан цахим сургалт.

“Оюу толгой” ХХК ба “Мандал Даатгал” ХК-ийн хооронд байгуулсан эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын гэрээг 2022 оны 4-р сар хүртэл сунгаж, зардлыг нэмэгдүүлэхгүйгээр хэд хэдэн сайжруулалтыг хийлээ. Эдгээрийг дурдвал:

- 1) Даатгалд хамрагдах эмнэлгүүдийн тоо нэмэгдсэн нь ажилтнуудын үйлчлүүлэх эмнэлгийн сонголтыг өргөжүүлсэн. Тухайлбал Мамба Дацангийн уламжлалт анагаах ухааны эмнэлгийг ажилтнууд сайшааж хүлээн авсан,
- 2) Архаг өвчний эмчилгээ болон жирэмсний хэвийн төрөлтийн нөхөн олговрын хязгаарыг нэмэгдүүлсэн,
- 3) “Мандал Даатгал” ХК-аас элэгний В, ханиадны вакцинжуулалтыг зохион байгуулахаар санал болгосон,
- 4) Ажилчдын гэр бүлийн гишүүд хөнгөлөлттэй үнээр даатгалд хамрагдах боломжтой болсон,
- 5) Урьдчилсан өргөдлийн маягт, нөхөн төлбөрийн баримт бичгийг цахимаар илгээх боломж бүрдсэн.

Компанийн зүгээс үзүүлэх тусламж дэмжлэг нь үүгээр хязгаарлагдахгүй болно.

## “Манлайллын хөгжлийн хөтөлбөр”-ийг өргөжүүлэх

2019 онд Оюу толгойн Үйл ажиллагаа, ЭМААБО, Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалтын хэлтсийн ахлах, дунд түвшний удирдах ажилтнуудаас бүрдсэн Манлайллын хөгжлийн байнгын хороог байгуулсан. Уг хорооны үйл ажиллагаа нь монгол удирдах ажилтнуудын хөгжилд төвлөрч, хэрэгцээнд тулгуурладаг. Дор дурдсан манлайллын үндсэн хөтөлбөрүүдийг 2023 оныг дуустал хэрэгжүүлнэ. Үүнд:

- » Бүх түвшний удирдах ажилтанд зориулсан Аюулгүй ажиллагааны хэлэлцүүлэг сургалт
- » Бүх удирдах ажилтанд зориулсан “Урам зоригийн манлайллын хөтөлбөр 2.0”
- » Өндөр ур чадвар бүхий дунд түвшний удирдах ажилтнуудад зориулсан “Ахисан түвшний хөгжлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

“Ахисан түвшний хөгжлийн хөтөлбөр” нь 2016 оноос эхлэн хэрэгжсэн бөгөөд 2020 онд хөтөлбөрийн агуулгыг улам баяжуулж, хөтөлбөрт оролцогчдын дунд бизнес шинэчлэлийн төсөл боловсруулах, санаачилсан төслийг бодитоор хэрэгжүүлэхэд зориулсан нарийн ур чадварыг эзэмшүүлэх сургалтын арга барилыг багтаасан. Түүнчлэн, 2021-2022 онд хөтөлбөрийн оролцогчдоо (24 оролцогч) улам хөгжүүлэх зорилгоор үйлдвэрлэл, үйл ажиллагааны үйл явцыг хамарсан сэдвээр хөтөлбөрийн агуулгыг баяжуулахаар ажиллаж байна.

“Урам зоригийн манлайллын хөтөлбөр 2.0” нь удирдах ажилтнуудын (650 орчим) хөгжлийг шат ахиулахад нь дэмжлэг үзүүлэхийг зорьдог. Энэхүү хөтөлбөр нь дор дурдсан 6 модулиар манлайллын тусгай ур чадвар, зан үйлийг төлөвшүүлэхэд анхаардаг. Үүнд:

- » Үйлдлээрээ үлгэрлэх – үр ашигтай багийн удирдагч, багийн гишүүн байх,
- » Бусдад ажиллах боломж олгох – 1:1 манлайлал
- » Алсын хараан дор бүгдийг нэгтгэ – байгууллагын соёл, соёлын өөрчлөлт,
- » Тогтсон дэгийг өөрчлөхөөс бүү ай – асуудлыг шуурхай шийдвэрлэх,
- » Шударга харилцаа, ур чадварыг үнэлэх нь (5, 6-р модуль).

## “ОТ бидний бахархал” амжилт сайшаах хөтөлбөрийг өргөжүүлэх

“ОТ Бидний бахархал” амжилт сайшаах хөтөлбөр нь Оюу толгойн ажилтнууд байгууллагын үнэт зүйлс, соёлыг хэрхэн бэхжүүлж байгааг жишээгээр онцлон тэмдэглэдэг албан ёсны арга хэмжээ юм. Энэхүү хөтөлбөрт Оюу толгойд ажилладаг бүх ажилтан хамрагдах боломжтой. 2020 онд аюулгүй ажиллагаанд хувь нэмэр оруулсан хүн бүрийг урамшуулан сайшаах үүднээс “КОВИД-19 цар тахлаас сэргийлэх” гэсэн шинэ ангиллыг бий болгосон.

## Хүний нөөцийн үйлчилгээг тасралтгүй сайжруулах

Цаг бүртгэлийн автоматжуулалт:

Уурхайн ажилтнууд цаг бүртгэлээ цаасан маягтаар бөглөдөг байсныг нислэг болон хүний нөөцийн системийн мэдээллийг ашиглан автоматжуулж, цахим маягтад шилжүүлснээр ажилтнуудад ашиглахад илүү хялбар болж, улмаар цаг хэмнэхээс гадна хүн хүчний оролцоог багасгаж, өгөгдөл мэдээллийн үнэн зөв байдал нэмэгдсэн.

“Manage Engine” дугаараар хянан удирдах систем: Энэ нь хүний нөөцийн үйлчилгээний бүх стандарт хүсэлтийг нэг талбарт төвлөрүүлж, харилцагчдад дахин давтагдахгүй дугаараар хүсэлтийнхээ явцыг хянаж, удирдах боломж олгосон систем юм. Гол давуу талыг дурдвал:

- » Үйл явцын шат дараалал нь тодорхой, харагдахуйц болсноор эцсийн хэрэглэгчийн хувьд ашиглалт сайжирсан,
- » Хянах, тайлагнах ажлыг автоматжуулсан,
- » Хүний үйлдлээс гарч болзошгүй алдаа багассан.

## Гүний уурхайн үйлдвэрлэлийн хүний нөөц бүрдүүлэлт

Гүний уурхайн олборлолт, тээврийн түвшний бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх хүний нөөцийн бүрдүүлэлтийг 2020 оны гуравдугаар улиралд эхлүүлж, ес, аравдугаар сард Оюу толгой уурхайн цогцолборт үндсэн болон гэрээт компанийн олон мянган ажилтныг хамарсан өргөн хэмжээний кампанит ажил зохион байгуулсан.

Сонирхсон ажлын байрандаа өргөдөл гаргах, карьер хөгжлийн бусад асуудлаар зөвлөгөө, тусламж авах хүсэлтэй хүмүүст зориулан зөвлөгөө өгөх уулзалтыг цахимаар болон ариутгал, хамгааллын дэглэмийг сахин биечлэн зохион байгуулсан. Эдгээр уулзалтад давхардсан тоогоор 3,000 гаруй ажилтан, үүний дотор цөөнгүй эмэгтэй болон орон нутгийн ажилчид хамрагдсан.

## Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх

“Оюу толгой” компанид бид аюулгүй ажиллагааг хангах, ур чадварыг хөгжүүлэх, инновацыг дэмжих зорилтын хүрээнд сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлдэг. “Оюу толгой” компанийн сургалтын хэлтэс 2012 онд байгуулагдсанаасаа хойш дэлхийн хэмжээний уурхайг ажиллуулах ур чадвартай ажиллах хүчнийг бүрдүүлэх, Монголын ирээдүй, хойч үеийнхний хөдөлмөр эрхлэх чадвар, чадавхыг улам сайжруулах зорилгоор боловсролын болон техникийн чиглэлийн сургалтын салбарыг дэмжиж ажиллах нэн тэргүүний зорилтыг дэвшүүлж ажилласан.

Зөвхөн 2020 онд л гэхэд бид Оюу толгойд аюулгүй ажиллагааны сургалтаас авхуулаад орчин үеийн тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлээр нийт 407,732 хүн/цагийн сургалт явуулж, 12,061 ажилтныг хамруулж сургасан байна. Ажилчид, гэрээт гүйцэтгэгчдийн өмнө хүлээсэн бидний үүрэг бол хүн бүрд ямар нэгэн осол зөрчилгүй, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Дэлхийн жишигт нийцсэн уурхайг ажиллуулахын тулд монголчуудын ур чадварыг хөгжүүлж, мэргэшүүлэх нь манай бизнесийн тэргүүнд тавих зорилтуудын нэг бөгөөд бидний амжилтын тулгуур юм. Насан туршийн мэдлэг боловсролыг олгож, хамгийн орчин үеийн ур чадвар, мэдлэгийг ажилчдадаа эзэмшүүлэхийг зорьж, тэднийг дэмжиж ажилладаг.

2020 онд Баяжуулах үйлдвэрийн 20 оператор Оюу толгой-Эрдэнэт Технологийн дээд сургуулийн хамтын ажиллагааны хөтөлбөрт хамрагдан, Уул уурхайн чиглэлээр бакалаврын зэрэг эзэмшиж төгссөн. Энэхүү хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь одоо хэрэгжиж буй ОТ-н операторыг хөгжүүлэх хөтөлбөр дээр суурилсан бөгөөд Эрдэнэт Технологийн Дээд Сургууль нь бидний

хамтын ажиллагаа, сургалтын өндөр түвшний стандартыг түгээн таниулах тал дээр түлхүү оролцоотой ажилласан. Оюу толгойн гүний уурхайг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн авч явах үйл явц нь Монгол Улсад урьд өмнө байгаагүй мэргэшил, ур чадвар шаардаж байгаа бөгөөд гүний уурхайн ашиглалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрүүд нь дэлхийн түвшний ур чадавхыг Монголд цогцлоон бий болгох үйлсийг манлайлж байна.

2020 онд бид 14,154 хүнийг 280 шинэ техник, тоног төхөөрөмж дээр сургаж дадлагажуулсан байна. Рио Тинтогийн бусад уурхайтай хамтран “Оюу толгой”-н ирээдүйн ажиллах хүчнийг сургаж бэлтгэх чадавхыг бүрдүүлж байна. Хоёр монгол залуу мэргэжилтнийг гүний уурхайг блокоор агуйлан олборлоход шаардагдах технологитой танилцуулахаар Австрали дахь Рио Тинтогийн Аргайл уурхайд томилж ажиллуулсан.

Бид цаг ямагт хамгийн сайн туршлагыг эрэлхийлэн судалж, бүхий л үйл ажиллагаандаа инновацыг хөгжүүлэхийг эрмэлздэг. Өнөө цагийн технологийг ашиглан бид Оюу толгойн бүх хэрэглэгчдэд сургалтыг хүртээмжтэй, энгийн болгох системийг боловсруулсаар байна. Гэрээт гүйцэтгэгчдэд зориулсан Оюу толгойн сургалтын удирдлагын систем нь Рио Тинтогийн хэмжээнд хамгийн шилдэг нь бөгөөд гэрээт гүйцэтгэгчид сургалтын үйл явцаа хянах боломжтой нэмэлт функцээр тасралтгүй шинэчлэгдэж байдаг. Уг үйл явцыг ийнхүү хялбарчилснаар ойролцоогоор 120,000 ам.долларын хэмнэлт гаргасан.

### **Тогтвортой байдлыг хангах**

Боловсон хүчний ур чадварыг хөгжүүлэх Оюу толгойн хөтөлбөр нь мэргэжилтэй боловсон хүчнийг шат дараатай бэлтгэх боломжийг бэхжүүлж, Монгол Улсад мэргэжлийн боловсролын

салбарыг дэмжиж байгаа юм. “Оюу толгой” компани ШУТИС-тай хамтран геотехникийн мэргэжлээр бакалавр, магистрын зэрэг олгох шинэ хөтөлбөр боловсруулах ажлыг ивээн тэтгэн, үйлдвэрлэлд суурилсан дээд боловсролыг дэмжих үйлсэд Монгол Улсдаа анхдагч нь болж байгаа билээ. Энэхүү санаачилга нь дээд боловсролын шинэчлэлийн үлгэр жишээ болж, Монгол Улсад дээд боловсролын ирээдүйн суурь өөрчлөлтийн үндэс суурийг тавьсан юм.

Геотехникийн шинэ хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж, 25 монгол залуу Монгол Улсад нэн шаардлагатай байгаа мэргэжлээр суралцаж эхлээд байна.

2020 онд их дээд сургуулийн 30 оюутан “Оюу толгой” компанийн дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан. Бид монгол залуус эрдэм боловсрол, ур чадварыг эзэмшин, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахад нь тусалж байгаадаа баяртай байна.

Компанийн баримталдаг үнэт зүйлийн хүрээнд Өмнөговь аймгийн иргэдийн чадавхыг бэхжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна. Оюу толгой компани, Өмнөговь аймгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хэсэг байгуулж, олон санал санаачилга, хөтөлбөрийг хэрэгжүүлж, тус аймагт ажил эрхлэлтийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлсэн.

Бид Өмнөговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хэсгийн 5 жилийн хамтын ажиллагаагаа өнгөрсөн онд дүгнэлээ. Хамтарсан ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Өмнөговь аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин тогтвортой буурч, улсын дундажтай харьцуулахад хамгийн доод түвшинд хүрсэн байна.









# Түншлэгч талуудын хамтын ажиллагаа

Манай үйл ажиллагааны тэргүүлэх таван чиглэлийн нэг бол Түншлэл билээ. “Оюу толгой” компани орон нутгийн иргэдтэй сайн хөршийн нягт харилцаатай ажилладаг. КОВИД-19 цар тахлын үед бид дараах байдлаар түншлэлээ бэхжүүллээ. Үүнд:

## Орон нутгийн оролцогч талуудтай хамтран ажиллаж, хамтын үнэ цэнийг бүтээнэ

### 2020 оны зорилго

- » КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх,
- » Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт, үүрэг амлалтын биелэлт,
- » Орон нутгийн тогтвортой, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих,
- » Гурван талт зөвлөлийн тогтвортой үйл ажиллагаа, хоёр гэрээний хэрэгжилт,
- » Орон нутгийн ажил эрхлэлт, худалдан авалтыг дэмжих замаар эдийн засгийн хөгжилд нь хувь нэмрээ оруулах,
- » Нийгмийн эрсдэлийн шинжилгээ, Австралийн Жуукан хавцлын явдлаас авсан сургамжууд.

### Гүйцэтгэл

Бид нийгэм, байгаль орчинд үзүүлэх аливаа нөлөөллийг зохистой удирдан, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжилд хувь нэмрээ тууштай оруулж, тогтвортой хөгжлийг бүх боломжоор дэмжин, орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцаагаа бэхжүүлэх эрхэм зорилготой ажиллаж байна. Орон нутгийн харилцаа болон хамтын ажиллагаандаа харилцан итгэлцэл, ил тод байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ, компанийн үнэт зүйлс болон “Бидний ажлын арга барил” баримт бичгийн зарчмыг ягштал баримталдаг.

### КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

“Оюу толгой” компани КОВИД-19 цар тахлын нөлөөллийг бууруулах чиглэлээр орон нутгийн оролцогч талуудтай бүх талаар хамтран ажиллаж, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангах боломжийг бүрдүүлж, орон нутгийн онцгой байдлын хариу арга хэмжээ авах чадавхыг дээшлүүлэхэд бодитой дэмжлэг тусламж үзүүлэн ажиллаж байна. “Говийн Оюу” Хөгжлийг Дэмжих Сангаар (ГОХДС) дамжуулан Өмнөговь аймаг, Ханбогд сумын Онцгой байдлын хороонд 210 сая төгрөг хандивлалаа. НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж буй Өмнөговийн эрүүл мэндийн нэгдсэн хөтөлбөрийн үйл ажиллагаанаас гадна бид хөрш зэргэлдээ орон нутгийнхаа КОВИД-19 цар тахлын эсрэг яаралтай арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх үйлсэд нь шууд болон ГОХДС-аар дамжуулах байдлаар хандив тусламж үзүүллээ.

Бид НҮБ-ын Хүн амын сантай хамтран КОВИД-19 болон бусад халдварт өвчний оношилгоо, эрт оношилгоог сайжруулах, Өмнөговь аймгийн Бүсийн оношилгооны төвийн алсын зайн оношилгоо, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Түүнчлэн Даланзадгад, Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдын эмзэг бүлгийн иргэдийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор 250 сая төгрөгийн хүнсний хандив өргөөд байна.

### Орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр, Хамтын ажиллагааны гэрээний үүрэг амлалтын биелэлт

“Оюу толгой” компани нь эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсийг бүтээх алсын хараагаа удирдлага болгож, Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийн төлөө тууштай хөрөнгө оруулалт хийж, Хамтын ажиллагааны

гэрээ, "Говийн Оюу" Хөгжлийг Дэмжих Сангийн хүрээнд хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэн ажиллаж байна. 2020 онд бид Хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсаны болон "Говийн Оюу" Хөгжлийг Дэмжих Сан (ГОХДС) байгуулагдсаны 5 жилийн ойг орон нутгийн түншүүдтэйгээ тэмдэглэн өнгөрүүллээ. Өмнөговь аймаг, Ханбогд сум, "Оюу толгой" ХХК-ийн хооронд 2015 онд байгуулагдсан Хамтын ажиллагааны гэрээнд тохиролцсоны дагуу "Оюу толгой" компани нь ГОХДС-нд жил бүр таван сая ам.долларын хандив өгдөг. ГОХДС нь Хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх үүрэг бүхий хуулийн этгээд бөгөөд 2015-2020 онуудад "Оюу толгой" компаниас 27 сая гаруй ам.долларын санхүүжилт хүлээн аваад байна. Тус хөрөнгөөр нийгмийн болон хөгжлийн чиглэлийн 250 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж ирсэн.

"Оюу толгой" компанийн хөрөнгө оруулалтын үр дүнд орон нутагт 426 байнгын ажлын байр шинээр бий болж, давхардсан тоогоор орон нутгийн 480,000 иргэн төслийн үр шимийг хүртээд байна. ГОХДС нь орон нутгийн засаг захиргаа, компанийн төлөөлөл хамтын оролцоотойгоор "Оюу толгой" компанийн санхүүжилтийг зарцуулах шийдвэрийг гаргадаг тогтолцоотой бөгөөд санхүүжилтийн ил тод байдлыг хангах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол өгч ажиллаж байна.

ГОХДС нь 2015-2020 онд Өмнөговь аймгийн 234 оюутанд 523.8 сая төгрөгийн тэтгэлэг олгож, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд дэмжлэг үзүүллээ. ГОХДС нь залуу үеийнхний хөгжиж дэвшихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Оюу толгойн нийт хөрөнгө оруулалтын таван хувийг "Ирээдүй хойчийн сан" -д хуримтлуулж байна.

Сүүлийн таван жилийн хугацаанд, ГОХДС нь Өмнөговь аймгийн сум орон нутагт сургууль, цэцэрлэг, эмнэлэг, спортын ордон, музей, уурын зуух, ус цэвэршүүлэх байгууламж, хогийн цэг, үерийн далан, малчдын худаг зэрэг нийгмийн дэд бүтцийн 90 төсөлд хөрөнгө оруулалт хийсэн. 2020 онд Ханбогд суманд Малын тэжээлийн агуулах, Хог хаягдлын байгууламж, Даланзадгад сумын Соёл спортын цогцолборт Усан бассейн зэрэг олон нийтийн байгууламжийн барилга угсралтын ажлыг хэрэгжүүлж ашиглалтад оруулсан. Мөн Даланзадгад сумын гэр хорооллын бүсэд 200 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг, Гашуунсухайт хилийн боомтод Харуул хамгаалалтын цамхаг байгуулах шинэ бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэн ажиллаж байна.

## **Орон нутагт тогтвортой хөдөө аж ахуйн бизнесийг дэмжин, хүртээмжийг дээшлүүлэх**

2020 онд "Оюу толгой" компани орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, хүнсний аюулгүй байдал, аюулгүй ажиллагаанд хувь нэмэр оруулах зорилгоор хөдөө аж ахуйн тогтвортой, хүртээмжтэй бизнесийг дэмжих ажлаа үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. Ханбогд дахь Сум дундын мал эмнэлэг нь бүс нутагтаа хамгийн томд тооцогдох бөгөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, ноос, ноолуур, арьс шир зэрэгт бүрэн шинжилгээ хийх чадвартай лабораторийн шинэ тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал амьтны эрүүл мэндийг сайжруулах үйлсэд томоохон хувь нэмэр болох төв юм. 2020 онд бүрэн ажиллагааг хангахын тулд тус төвийг Улсын мал эмнэлгийн ерөнхий газрын удирдлагад шилжүүлэн, үйл ажиллагааны хамтарсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

2020 онд Ханбогд суманд Тогтвортой амьжиргааг дээшлүүлэх туршилтын төслүүдийн хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, маркетинг, ложистикийг хөгжүүлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн байна. "Оюу толгой" компаниас Ханбогдын малчин өрхийн нэмүү өртөг шингэсэн хөдөө аж ахуйн бизнесийн загварыг дэмжиж, орон нутгийн бизнесийн орчин, нүүдэлчдийн амьжиргаанд тохирсон тогтвортой амьжиргааг дэмжих шинэ төслүүдийг санхүүжүүлсэн. Малчдын хоршоодын дунд бизнесийн төслийн удирдлагын сургалт зохион байгуулсан. 2020 онд нэмүү өртөг шингээх санаачилгын хүрээнд 81 хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч сургалтад хамрагджээ. Үүний үр дүнд Ханбогдод ирээдүйтэй бизнесийн төслүүд шинээр хэрэгжиж эхлээд байна. Малчин өрхүүд ашиг шим өндөртэй үхэр, хонины үүлдрийг өсгөх бизнес санаачлан эхлүүлж, 174 гавилууд үүлдрийн хурга, холимог үүлдрийн 45 ангус тугал хүлээн авч бойжууллаа. Мөн бизнесийн түншлэлийн стратегийн шинэ төслийг "ТЭСО" ХХК-тай хамтран эхлүүлж, ингэний сүүгээр дотоодын шинэ брэнд хүнсний бүтээгдэхүүн төрүүлэхээр ажиллаж байна. Энэхүү туршилтын төсөлд Ханбогд сумын 10 малчин өрхийг хамруулж, өвлийн улиралд долоо хоногт 2,300 л, зуны улиралд 19,000 л тэмээний сүү нийлүүлж байна.

## **Орон нутгийн эдийн засаг, ажил эрхлэлт, худалдан авалтыг дэмжих**

"Оюу толгой" компани нь орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, худалдан авалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих замаар уурхайн үр шимийг орон нутагт хүртээхэд анхаарлаа төвлөрүүлсээр ирсэн. 2020 оны эцсийн байдлаар компанийн дотоодын нийт худалдан авалтын 22%-ийг Өмнөговийн ханган нийлүүлэгчид, мөн нийт ажилтны 27%-ийг Өмнөговийн иргэд тус тус бүрдүүлж байв.

"Оюу толгой" компани Германы хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), "Говийн Оюу" Хөгжлийг Дэмжих Сан (ГОХДС), Өмнөговь аймгийн захиргаатай хамтран 'Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх түншлэлийн хөтөлбөр'-өөр дамжуулан жижиг, дунд бизнесийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Бизнесийн инновац, өсөлтийн төв (БИГ төв) нь Улаанбаатар хот болон Өмнөговь аймагт 2019 онд байгуулагдсан бөгөөд Өмнөговийн бизнес эрхлэгчид, ЖДҮ эрхлэгчдэд зориулсан эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандарт, бизнесийн ёс зүй шударга байдал, бизнесийн удирдлага, хангамжийн сүлжээний менежмент, бизнесийн менежментийн чиглэлээр төрөл бүрийн сургалтууд зохион байгуулж байна. Мөн дэлхийн хэмжээний уул уурхай болон бусад салбарын хэрэгцээг хангахын зэрэгцээ өрсөлдөх чадвар, тогтвортой байдлаа сайжруулах, санхүүгийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2018-2020 онд чадавх бэхжүүлэх 266 сургалт, арга хэмжээнд 450 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, тэдний 3,521 ажилтан (эмэгтэй 58%, эрэгтэй 42%) хамрагджээ. Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд гарааны бизнес эхлүүлэх, төсөл, судалгаа, боловсруулалт, инновац, бизнесийн өргөжилтийг дэмжихэд чиглүүлсэн 446 сая төгрөгийн шууд хөрөнгө оруулалт хийж, бусад эх үүсвэрээс 2 тэрбум гаруй төгрөгийн санхүүгийн хөрөнгө оруулалтыг татсан байна.

ГОХДС-ийн санхүүжилтээр ХААН банкны хэрэгжүүлж буй "Говийн Оюу - Бизнесийн боломж" бичил зээлийн хөтөлбөр 2016 оноос хойш хэрэгжиж байна. Тус хугацаанд Өмнөговь аймгийн орон нутгийн 51 бизнес эрхлэгчид 1.4 тэрбум төгрөгийн бизнесийн зээл олгож, шинэ ажлын байр, орон нутгийн бизнес, үйлчилгээг бий болгоход дэмжиж ажиллалаа.

### **Гурван талт зөвлөлийн тогтвортой үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт**

2020 онд Ханбогд сумын Гурван талт зөвлөл (ГТЗ)-өөр дамжуулан орон нутгийн оролцогч талуудтай хийх хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, онлайн сувгаар дамжуулан ГТЗ-ийн үйл ажиллагааны ил тод байдал, тайлагналыг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа. Малчдын гомдлыг шийдвэрлэх гэрээнд тохиролцсон амлалт, тогтвортой амьжиргааны төслүүдийн хэрэгжилтийн ерөнхий явц 69 хувийн гүйцэтгэлтэй байна. 2017-2020 онд "Оюу толгой" компаниас гэрээний хэрэгжилтийг хангахад 1.8 сая ам.долларын санхүүжилт олгосон байна. Энэхүү гэрээний гол зорилтуудын нэг болох малчин өрхөд олгох уурхайн нөлөөллийн нөхөн олговрын нэхэмжлэлийг шийдвэрлэх ажил амжилттай хэрэгжиж, дуусах шатандаа явж байна. Энэ хүрээнд ГТЗ-ийн гишүүдийн баталсан 160 нэхэмжлэлийн дагуу Ханбогд сумын 157 малчин өрхөд нийт 1.4 сая ам.долларын нөхөн олговор олгожээ.

ГТЗ-ийн талуудын харилцан ойлголцол, итгэлцлийг бий болгох таатай орчныг бүрдүүлэх чухал алхам бол ил тод байдлыг сайжруулж, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлыг шийдвэрлэх дүрэм журмыг хэрэгжүүлэх явдал юм. 2020 онд ГТЗ-ийн Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг баталж, мөн ГТЗ-ийн мэдээллийг нийгмийн сүлжээгээр түгээх ажлыг шуурхай болгоход чиглэсэн мэдээллийг олон нийтэд нээлттэй тавих дэс дарааллыг тогтоолоо.

### **Нийгмийн эрсдэлийн шинжилгээ**

Жуукан хавцалд болсон үйл явдлын талаар Рио Тинто группийн Удирдах зөвлөлийн зүгээс хийсэн байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээний дагуу нийгмийн эрсдэлийн өөрийн үнэлгээг өргөн цар хүрээнд хэрэгжүүлж Нийгмийн эрсдэлийн загвараа шинэчиллээ. Цаашид нийгмийн болон орон нутгийн эрсдэлийн удирдлагад хатуу чанга хяналт, засаглалын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн Рио Тинто группийн Орон нутгийн харилцааны нийцлийн гэрчилгээний шаардлагыг хангалаа.

## Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төсөл

Монгол Улсад жил бүр зам тээврийн ослоор 500 гаруй хүн амь насаа алдаж, хэдэн мянган хүн гэмтэж бэртдэг бөгөөд цаг бусаар хүний амийг авч оддог хамгийн том шалтгаан хэвээр байна. Зам тээврийн аюулгүй байдлын талаарх ойлголтыг олон нийтэд хүргэх, цаашлаад хүний эрүүл мэнд, амь насыг авран хамгаалах үүднээс Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), Мобиком корпорацитай урт хугацааны түншлэлийг эхлүүлээд байна. Бид хамтдаа хоёр дахь жилдээ нөлөөллийн аяныг орон даяар амжилттай зохион байгуулж, Дархан-Сэлэнгийн замд замд хурд хэмжигч байршуулахад дэмжин ажиллалаа.

- » “Яараад яахав дээ” нөлөөллийн аянаараа орон нутгийн замд зорчих зорчигчдод төвлөрч, нас баралт, гэмтэл бэртэл өндөр байдаг зун цагийг тааруулан зохион байгууллаа. КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор тогтоосон хөл хориог сулруулсны дараа хөдөө орон нутгийг зорих аялагчдын тоо 2020 онд 2 дахин өссөн нь эрсдэлийг мөн төдий чинээгээр нэмэгдүүлсэн. Гэсэн хэдий ч “Яараад яахав дээ” аян зохион байгуулагдсанаар нийт зам тээврийн осол 40 хувиар, гэмтэл бэртэл 30.5 хувиар тус тус буурсан дүн гарав. 21 аймагт буй тээврийн цагдаагийн алба хаагчид аяныг идэвхжүүлэн ажиллаж, урлаг соёлын одод, дуучид, жүжигчид зэрэг олны танилууд дэмжиж оролцлоо.
- » Орон нутгийн замд суурилуулсан хурд хэмжигчийн зарим үр дүнгээс: 2019 онд Чойр чиглэлийн замд хурд хэмжигч суурилуулснаас хойш тус замд гарах нас баралт 5 хувь, нийт зам тээврийн осол 18.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны 9 дүгээр сард Дархан-Сэлэнгийн замд хурд хэмжигч суурилуулснаас хойш тайлант хугацаанд осол, гэмтэл бүртгэгдээгүй сайн мэдээтэй байна. Эдгээр аймагт суурилуулсан хяналтын системийг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хурд хэтрүүлсэн эсэхийг шалгах, татвар, даатгал, оношилгоондоо хамрагдсан эсэхийг хянаж, илэрсэн зөрчилд арга хэмжээ аван, аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр ашиглах боломжтой юм.

Монгол Улсад зам тээврийн аюулгүй байдлыг бий болгож, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Оюу толгой” ХХК цаашид ч ЦЕГ-тай урт хугацаанд хамтран ажиллана.



## КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа

Энэхүү амаргүй цаг үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, тоног төхөөрөмжийн хүрэлцээг нэмэгдүүлэх үүднээс компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд дараах хандивыг тус тус өргөв.

1. “Рио Тинто Монгол”, “Оюу толгой” ХХК хамтран “КОВИД-19” цар тахлын эсрэг “Эрүүл мэндийн оношилгоо, зайн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд 1.7 тэрбум төгрөг,
2. Монголын Уул уурхайн үндэсний ассоциациар дамжуулж, Монгол Улсын Засгийн газарт 100 сая төгрөг
3. Өмнөговь аймгийн Онцгой комисст 200 сая төгрөг,
4. “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан”-гаар дамжуулж Ханбогд сумын Онцгой комисст 10 сая төгрөг,
5. Оюу толгойн нийт уурхайчин, хамт олны зүгээс Эрүүл мэндийн яаманд 145 сая төгрөг хандивлав.





# Стратеги хөгжил

## Гүний уурхайн төсөл

2020 онд КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр урд өмнө нь тулгарч байгаагүй сорилтуудтай нүүр тулсан авч "Оюу толгой" компани үйл ажиллагаагаа хэвийн удирдан явуулж, бүтээмжээ хадгалж, бат зогсож чадлаа. Ээлж сунаж ажиллах, орон нутаг болон олон улсын нислэг зогсох, гэрээсээ ажиллах, тусгаарлалт, хөл хорионд орох зэрэг багагүй сорилт бэрхшээлийг ажилтнууд маань даван туулж, шаргуу ажилласны ачаар манай үйл ажиллагаа аюул осолгүй, өндөр бүтээмжтэй үргэлжилж байна. Бид үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө олон үзүүлэлтээр давуулан биелүүлж, бахдам үр дүнд хүрлээ. Эдгээр ололт, амжилтад бид нийт ажилтнуудынхаа дотны хүмүүсийн дэмжлэггүйгээр хүрэх боломжгүй байсан билээ.

## Ажиллах хүчин

2020 онд бид аюулгүй ажиллагааны гүйцэтгэлээрээ дэлхийд өрсөлдөхүйц үзүүлэлтэд хүрч чадлаа. Тайлант хугацаанд гүний уурхайн бүтээн байгуулалтад нийт 12.7 сая хүн/цагийн ажил гүйцэтгэлээ. Ийнхүү 2016 оноос хойш Гүний уурхайн бүтээн байгуулалтад нийтдээ 64 сая хүн/цагийн ажил гүйцэтгээд байна. Бүх гэмтэл бэртлийн давтамжийн (БГДҮ) үзүүлэлт өмнөх оныхоос 32 хувиар сайжирч, 0.16-д хүрч, Гүний уурхайн бүтээлт байгуулалт эхэлснээс хойш БГДҮ-ийн дундаж 0.24 байгаа нь зорилтот түвшин 0.29-өөс давж биелсэн үзүүлэлт юм.

Гүний уурхайн нийт ажиллах хүчний 92 хувийг Монголчууд бүрдүүлж байна. Төслийн хүрээнд гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын багцууд хэрэгжиж дууссан, төслийн багийн гишүүд үйл ажиллагааны хэсэг нэгж рүү шилжсэн, бүтээмж дээшлүүлэх төслийн хэрэгжилт мөн түүнчлэн КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр тодорхой ажлууд хойшлогдсон зэргээс улбаалж төслийн нийт ажиллах хүчний тоо 7,100-аас 2,960 болж буурлаа.

"Оюу толгой" компанийн Бизнесийн тогтвортой байдлыг хангах баг ажилчдыг үнэн зөв мэдээллээр тогтмол хангаж ажилласны зэрэгцээ гэр бүлээсээ хол, уртасгасан ээлжээр ажиллах болсон ажилтнууддаа дэмжлэг үзүүлж, алжаал ядаргаа бууруулах нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Олон улсын нислэг зогссоны улмаас гадаад мэргэжилтнүүд маань хэзээ эх орондоо буцах нь тодорхойгүй хэвээр байна. Монгол ажилтнууд маань ч мөн адил ээлжийн тогтсон хуваарийн дагуу гэртээ харьж амрах, амралтаа дуусгаад ажилдаа эргэж орох нөхцөл боломж нь хязгаарлагдмал хэвээр байна.

## Барилгын ажил

Оюу толгойн гүний уурхайн төслийн хуваарь, зардлын талаарх шинэчилсэн мэдээллийг гаргалаа. Мөн түүнчлэн гүний уурхайн хүдэр зөөвөрлөх системийн бүтээн байгуулалтыг амжилттай ахиулж, 60 хувийг гүйцэтгээд байна.

Оны эхээр Агааржуулалтын хойд, амны нэвтрэлтийн ажил эхлэх зэрэг төслийн чухал ач холбогдолтой хуваарьт ажлуудыг саадгүй урагшлуулах үүднээс алсын зайн технологийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Бид бүтээн байгуулалтын ажлуудаа төлөвлөж байснаас 3 сараар түрүүлж гүйцэтгэн, оны турш энэ эрчээ хадгалж, улмаар 3 дугаар сард төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн дээд амжилт тогтоолоо. Гүний уурхайн нийт малталт, нэвтрэлтийн хэмжээ 47,675 эквивалент метрт хүрлээ.

Гүний уурхайн төслийн ахлах ажилтнууд 2020 онд гаргасан амжилт, хичээл зүтгэл, ур чадвараа үнэлүүлж, тушаал дэвшин ажилласаар байна.


## Туузан дамжуургын налуу ам

Туузан дамжуургын налуу амны баг малталт, нэвтрэлтийн ажлыг дуусгах дөхөж байна. Төсөл эхэлснээс хойш туузан дамжуургын налуу амны малталт, нэвтрэлтийн хэмжээ 12,069 эквивалент метрт хүрсэн бөгөөд 2020 онд 4,001 эквивалент метрийн гүйцэтгэлтэй байна

## **Гүний уурхайн багийн шилжилт**

Гүний уурхайн олборлолтын баг 10 дугаар сарын сүүлд Үйл ажиллагааны бүтцэд шилжсэн нь гүний уурхайн төслийн хувьд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо. Гүний уурхайн олборлолтын үндсэн ур чадварыг бий болгох, бэхжүүлэх, хөгжүүлэхэд хүчин зүтгэсэн өнөөгийн болон өмнөх үеийн удирдлагууд, багийн гишүүдийн нөр их чармайлтын хүчинд уг шилжилт амжилттай хэрэгжсэн юм. Мөн уг үйл ажиллагаа нь "Оюу толгой" компани гүний уурхайн олборлолтоо эхлүүлэхэд бэлэн болсныг илтгэж, удирдлагын багийн зүгээс хүлээлгэж буй итгэлийг бататган харууллаа.

Гүний уурхайн олборлолтын баг 800 гаруй хүнтэй бөгөөд одоо Олборлолт ба тээвэрлэлтийн түвшин дэх барилга угсралт, үйлдвэрлэлийн багийн хүний нөөц бүрдүүлэлтийн хүрээнд нэмж 90 гаруй ажилтныг сонгон шалгаруулах ажил явагдаж байна. Гүний уурхайн олборлолтын баг одоо огтлох малталтын ажлыг эхлүүлэхэд бэлтгэж, үйл ажиллагаагаа жигдрүүлж байна. Энэхүү шилжилтийг хийснээр ил уурхай, гүний уурхай, баяжуулах үйлдвэрийн төлөвлөлт, өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулах бүтэц, үйл ажиллагааны тогтолцоо бүрдэж, улмаар бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх юм.



# Эрчим хүч

## Оюу толгой дахь эрчим хүчний хэрэгцээ

Оюу толгой нь цахилгаан эрчим хүчний хувьд өндөр хэрэглээтэй төсөл юм. Оюу толгойн гүний уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд төслийн нийт эрчим хүчний хэрэглээ ойролцоогоор 250 МВт болох бөгөөд энэ нь Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн нийт чадлын 20 хувьтай дүйцэхүйц дүн юм.

## Эрчим хүчний хэрэглээний гол хүчин зүйлс:

- » Газрын гадаргаас 1,300 метрийн гүнд ажиллах уурхайчдын ажиллах орчин (агаар, ус, гэрэл, хоол унд гэх мэт) нь цахилгаан эрчим хүчнээс бүрэн хамааралтай,
- » Гүний уурхайн үйл ажиллагааг аюулгүй явуулж, блокоор агуйлах олборлолтыг тасралтгүй явуулахад найдвартай, тогтвортой цахилгаан хангамж нэн чухал,
- » Цахилгаан хангамжгүйгээр, өндөр үнэ цэнэ бүхий хүдрийн биетийг газрын гадарга руу гарган боловсруулах боломжгүй болж улмаар үйлдвэрлэл болон ашгийн хувьд томоохон хохирол учирна,
- » Цахилгаан эрчим хүчний зардал нь цалингийн зардлын дараа хоёрдугаарт орох үйл ажиллагааны зардлын томоохон бүрдэл хэсэг юм.

Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу Оюу толгойн эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангахаар “Оюу толгой” ХХК тууштай ажиллаж байна. Энэ хүрээнд Оюу толгойн төдийгүй улс орны эрх ашгийг хангах цахилгаан эрчим хүчний оновчтой шийдлийг олохоор “Оюу толгой” ХХК-ийн зүгээс Засгийн газартай нягт хамтран ажилласаар ирсэн билээ. 2018 оны 12-р сард “Оюу толгой” ХХК болон Засгийн газар хооронд Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай (ЭХЭҮЗТГ) гэрээ байгуулсан. Энэ гэрээнд Тавантолгой нүүрсний ордод тулгуурлан нүүрсний цахилгаан станцыг барьж байгуулах ерөнхий бүтэц, холбогдох зохицуулалтыг тодорхойлж өгсөн байдаг. Хэдийгээр дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулан нүүрсний цахилгаан станцын санхүүжилт олон улсын хэмжээнд хомстсон, үүнтэй холбоотой Оюу толгой төслийн зардал өсөх, улмаар хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах хугацаа хойшлох зэрэг сорилтууд тулгарч байсан хэдий ч “Оюу толгой” ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу нүүрсний цахилгаан станц барьж байгуулахаар хүчин чармайлт гарган ажилласан.

## 2020 онд гарсан ахиц дэвшил

- » 2019 онд ТТЦС-ын Зураг төсөл, хангамж, барилга угсралт (ЗТХБУ)-ын гэрээт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл явц болон техникийн гол судалгаануудыг хийж дуусгасны үндсэн дээр “Оюу толгой” ХХК нь станцын Техник, эдийн засгийн үндэслэлийг 2020 оны эхээр Эрчим хүчний яаманд хүргүүлсэн. Гэсэн хэдий ч 2020 оны 4 дүгээр сард Оюу толгойн барих ТТЦС-ын төслийг дэмжихгүй бөгөөд Тавантолгой орд газрыг түшиглэн төрийн өмчит цахилгаан станц (Тавантолгой дулааны станц буюу ТДЦС)-ыг төрөөс санхүүжүүлж, барьж байгуулахаар шийдвэрлэсэн болохоо Засгийн газар зарласан,
- » Энэхүү эрх зүйн шинэ үндэслэлийг бүрдүүлэх зорилгоор талууд ЭХЭҮЗТГ-ний Нэмэлт өөрчлөлтийн гэрээг (ЭХЭҮЗТГ-НӨГ) 2020 оны 6 дугаар сард байгуулав. Гэрээнд 2021 оны 3 дугаар сарын 1-ний дотор импортын эрчим хүчний гэрээнүүдийг сунгах, ТДЦС-ын барилга, угсралтын ажлыг 2021 оны 7 дугаар сар гэхэд эхлүүлэх, мөн 2025 оны 7 дугаар сар гэхэд найдвартай эрчим хүчээр Оюу толгойн төслийг хангаж эхлэх зэрэг үндсэн хуваарьт ажлуудыг тусгасан,
- » 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр “Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК болон “Оюу толгой” ХХК-ийн төлөөлөл “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-нд гарын үсэг зурсан бөгөөд 35 кВ-ын дамжуулах станцаар дамжуулан Оюу толгойн эрчим хүчний зарим хэрэглээг хангаж эхэллээ. “Оюу толгой” ХХК-тай байгуулсан “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ” нь эдийн засагт эерэг үр дүн авчрах юм,



- » 2020 оны 10 сарын сүүлээр дотоодоос эрчим хүчээр хангах хэлэлцээрийг хийх ажлын хэсгийг Эрчим хүчний яамны дэргэд байгуулсан ба 2020 оны 11 сард Оюу толгой уурхайн эрчим хүчний хэрэглээг ТДЦС-аас шууд хангахгүйгээр МУ-ын нэгдсэн сүлжээнээс хангана гэж мэдэгдэв. Энэ нь Засгийн газрын зүгээс үндсэн чиглэлээ дахин өөрчилсөн явдал болсноос гадна ялангуяа Диспетчерийн үндэсний төвөөс хийсэн горимын тооцооноос үзэхэд Оюу толгойг найдвартай эрчим хүчээр хангахын тулд ТДЦС-аас гадна МУ-ын нэгдсэн сүлжээнд хэд хэдэн эх үүсвэр болон дамжуулах дэд бүтцүүдийг барьж байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлттэй холбогдуулан Оюу толгойд ирэх эрсдэлийн түвшинг нэмэгдүүлсэн,
- » Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс хангах хувилбарыг авч үзэх арга замыг тодорхойлж, шийдэлд хүрэхийн тулд Оюу толгойн зүгээс Эрчим хүчний яамтай үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна. Энэ шинэ чиглэлийг цааш хөгжүүлэхийн тулд шинээр эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх шаардлагатай болж байгаа юм.

## 2021 оны төлөв


Ажиллах хүч, дэд бүтэц, нөөц баялаг, орлогын эх үүсвэрээ хамгаалахын тулд эрчим хүчний найдвартай, тогтвортой байдлыг хангах нь Оюу толгойн хувьд эн тэргүүний зорилго юм. Монгол Улсын нэгдсэн сүлжээнээс хангах эрх зүйн шинэ үндэслэлийг бүрдүүлэх хүртэл ЭХЭҮЗТГ-НӨГ нь Оюу толгойн богино болон урт хугацааны эрчим хүч хангамжийн талаар баримтлах үндсэн гэрээ хэвээр байна. Мөн Оюу толгой төслийг хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт шаардлагатай тул эрх зүйн сайн зохицуулалттай байх нь Оюу толгой болон түүний хувьцаа эзэмшигчид төдийгүй Оюу толгойн өнөөгийн болон ирээдүйн зээлдүүлэгч, хөрөнгө оруулагчдад нэн чухал юм.

# Маркетинг ба борлуулалт

“Оюу толгой” компани 2020 оны турш борлуулалтын гэрээний стратегидаа анхаарч ажиллалаа. “Оюу толгой” компанийн Маркетингийн баг спот болон урт хугацаат гэрээний борлуулалтын харьцааг оновчтой болгосноор борлуулалтын үнэ, бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлж, борлуулалтын төрөлжсөн, тэнцвэртэй багц бүрдүүлж байна. Мөн удахгүй нийлүүлэгдэж эхлэх гүний уурхайн бүтээгдэхүүний худалдан авагчдын бааз суурийг бий болгохоор ажиллаж байна.

2012 онд байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд “Оюу толгой” компани “Фейшан” зэс хайлуулах үйлдвэртэй хамтран ажиллаж, 5 жилийн гэрээний гурав дахь жилийг амжилттай дуусгаад байна. Мөн КОВИД-19 цар тахлын үед БНХАУ-ын зах зээлд бүтээгдэхүүнээ саадгүй борлуулахын тулд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Баяннуур аймгийн захиргаа болон “Фейшан” зэс хайлуулах үйлдвэртэй нягт хамтран ажиллаж байна.

“Оюу толгой” компанийн 2020 оны турш бүтээгдэхүүнээ тогтвортой нийлүүлснийг манай худалдан авагчид өндрөөр үнэллээ.



# КОВИД-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээ

Компанийн зүгээс КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж, нийт ажилтан, орон нутгийн ард иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэн, бизнесийн тэргүүлэх зорилтуудаа биелүүлэхийн төлөө хичээн ажиллаж байна. Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой Комисс, Өмнөговь аймаг болон Ханбогд сумын орон нутгийн удирдлагуудын гаргасан заавар, шийдвэрүүдийг чанд мөрдөж ажиллаж байна.

Эрүүл мэнд, эрүүл ахуй, эрүүл оршихуйн төсөл санаачилгуудаар дамжуулан 2020 оны туршид КОВИД-19 цар тахлаас сэргийлэх, хариу арга хэмжээ авахад анхаарч, эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөөт бусад үйл ажиллагаанаас чухалчилж ажиллалаа. "Оюу толгой" компанид хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээнээс дурдвал:

- » "Оюу толгой" уурхайн цогцолборын эрүүл мэндийн төвд халдвар хамгааллын онцгой дэглэм нэвтрүүлээ,
- » Эрүүл мэндийн ажилтнуудыг халдвар хамгааллын сургалт, давтан сургалтад тогтмол хамруулж байна.
- » Халдвар хамгаалал, эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн гаднын мэргэжилтнүүдээс 6 сарын турш зөвлөгөө, мэдээлэл авч ажиллалаа,
- » Компанийн ахлах удирдлагуудаас бүрдсэн, Гүйцэтгэх захирлаар ахлуулсан Бизнесийн тогтвортой байдлыг хангах багийг КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалд тусгайлан байгууллаа,
- » Үйл ажиллагааны шуурхай багийг КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалд тусгайлан зориулж байгууллаа,
- » "Оюу толгой" уурхайн цогцолборт ирж буй хүн болгоноос түргэвчилсэн болон PCR (ПГУ) шинжилгээг 4 үе шаттайгаар (Оюу толгойн уурхайн цогцолбор руу хөдлөхөөс 48 цагийн дотор, хөдлөх үед, уурхайн цогцолборт ирснээс 4-6 хоногийн дотор, уурхайн цогцолбороос гарахаас 48 цагийн дотор) авч байна. Энэхүү урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь "Оюу толгой" уурхайн цогцолборыг КОВИД-19 халдвараас ангид байлгахад чиглэсэн арга хэмжээ юм,
- » Ээлжээр ажиллаж буй үндсэн болон гэрээт ажилтнуудыг шинжилгээнд хамруулах зорилгоор Улаанбаатар хот, Оюу толгойн уурхайн цогцолбор, Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдад шинжилгээний цэг байгууллаа,



- » Уурхайн цогцолборын төв хаалга, нисэх онгоцны буудал, "Мазаалай" хоолны газар, гүний уурхайн босоо аманд биеийн халуун хэмжих автомат хаалга суурилууллаа,
- » Уурхайн цогцолбор дээр халдвар хамгааллын чанд дэглэм мөрдүүлж, амны хаалт заавал зүүх, гар угааж ариутгах цэгүүдийг нэмэгдүүлэх, тээврийн хэрэгсэлд суудал алгасаж суух, хөл хөдөлгөөн ихтэй газруудад биеийн халуун хэмжих автомат төхөөрөмж суурилуулах, гар аргаар хэмжих зэрэг арга хэмжээ авч байна,
- » Ажилтнуудыг цар тахлын нөхцөл байдлын талаар тогтмол мэдээллээр хангах, халдвар хамгааллын дэглэгийг таниулах зэргээр нягт харилцаа холбоотой ажиллаж байна.

Цар тахлын улмаас Ханбогд сумын эмнэлгийг сайжруулах ажлыг түр хойшлуулахад хүргэсэн. Ханбогд сумын эмнэлгийн эмч, ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, "Оюу толгой" компанид ажилд орохын өмнөх болон жил тутмын эрүүл мэндийн үзлэгийг компанийн стандартын дагуу хийдэг болгох төслийг 2021 оны сүүлээр хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалд бэлтгэлтэй байж, хариу арга хэмжээ авч ажилласны үр дүнд Гүний уурхайн төсөл, Ил уурхайн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Цар тахал 2021 онд үргэлжилнэ гэсэн төсөөлөлтэй байна.

### **Ажилтнуудын эрүүл амьдралын хэв маягийг дэмжих чиглэлээр 2020 онд хэрэгжүүлсэн ажил:**

- » Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ: "Оюу толгой" компанийн ажилтнуудын эрүүл мэндийн нөхцөл байдлыг үнэлэх томоохон (1,693 хүнийг хамруулсан) судалгаа,
- » Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих 8 долоо хоногийн уралдаан,
- » Тамхинаас гарах кампанит ажил,
- » Ажил эхлэхийн өмнөх уулзалтаар эрүүл амьдралын хэв маягийг дэмжих асуудлыг хэлэлцэх (улирлын томуу, томууны вакцинжуулалт, сэтгэцийн эрүүл мэнд, алжаал ядаргаа, эрүүл хооллолт, халдварт бус өвчлөл, архины хамаарал, ходоод гэдэсний өвчлөл зэрэг сэдвээр сар тутам хэлэлцүүлэг өрнүүлэх),
- » Жирэмсний үеийн зөвлөмж,
- » Уул уурхай, эрдэс баялгийн салбарын эмэгтэйчүүдийн холбоо, "СОС Медика" олон улсын эмнэлэгтэй хамтран хөхний хорт хавдрын талаар сургалт, танилцуулга,
- » "Мазаалай" хоолны газарт "Та зүгээр үү?" өдөрлөг,
- » Уурхайн цогцолбор дээр нийтийн гүйлт,
- » Алжаал ядаргааны талаар 3 дахь удаагийн судалгаа, тоон мэдээ цуглуулах, боловсруулах ажил тус тус хийлээ.

### **Цар тахлын эсрэг хүчин чармайлтад 1.7 тэрбум төгрөг хандивлав**

КОВИД-19 цар тахалтай хийх тэмцэл, цар тахлын нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Рио Тинто", "Оюу толгой" компаниуд 602 мянган ам.доллар буюу ойролцоогоор 1.7 тэрбум төгрөгөөр Монгол Улсын цар тахлын эсрэг үйл ажиллагааны тогтвортой байдлыг бэхжүүлэх, хариу үйлдэх чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр шинээр санхүүжүүлэхээр боллоо.

Өнөөгийн бэрх цаг үед "Рио Тинто", "Оюу толгой" компаниуд НҮБ-ын Хүн амын сан болон улс, орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх суурь арга хэмжээг дэмжих зорилгоор хамтран ажиллаж байна.

Энэхүү түншлэлийн үндсэн зорилго нь эрсдэл өндөртэй, ар гэрийн гачигдал, санхүүгийн чадавх султай иргэдэд үйлчилдэг эрүүл мэндийн нэгжийн чадавхыг сайжруулж, КОВИД-19 болон бусад төрлийн халдварт өвчнийг оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлэх, КОВИД-19 цар тахлын үед мэргэжлийн эмчийн тогтмол үзлэгт хамрагдах шаардлагатай, эрсдэл өндөртэй өвчтөн, жирэмсэн эмэгтэйчүүдэд зайн оношилгоо, эмчилгээ үйлчилгээг чанартай, цаг алдалгүй хүргэх явдал юм.



## Оношилгооны чадавхыг нэмэгдүүлнэ

Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг, Яармаг дахь Нийслэлийн КОВИД-19/Эх, хүүхдийн эмнэлэг, ЭХЭМҮТ-д оношилгооны үйлчилгээний нэгжийг байгуулна:

» Лабораторийн дараах төхөөрөмжийг нийлүүлнэ:

- Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг, Яармаг дахь КОВИД-19/Нийслэлийн Эх, хүүхдийн эмнэлэгт тус бүр гурван ширхэг термоциклийн төхөөрөмж. ЭХЭМҮТ-д нэг термоцикл байдаг,
- Полимеразийн гинжин урвал (ПГУ)-ын дөрвөн лаборатори,
- ДНХ-тэй ажиллах дөрвөн бичил хурилдуур,
- Цельсийн -70 градусын дөрвөн ширхэг хөлдөөгч,
- ДНХ, РНХ ялгах төхөөрөмж,
- КОВИД-19 праймер, ПГУ-ийн урвалж.

Лабораториудыг дээрх төхөөрөмжөөр хангаснаар халдварт өвчний оношилгоонд тавигддаг олон улсын стандарттай нийцэхийн сацуу холбогдох хэрэгцээт төхөөрөмжөөр хангана. Европын Холбооны санхүүжилтээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж лабораторийн боловсон хүчийг сургаж бэлтгэнэ.

## Зайн оношилгоо, эмчилгээ

Мэргэжлийн эмчийн байнгын үзлэгт орох ёстой хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах нөхцөл бүрдэнэ:

- » Эх, нярай, хүүхэд, өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, дотор, эндокринологи, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй анхан шатанд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнуудыг холбох, цахимаар зөвлөлдөж, улмаар эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэх тухай заавар боловсруулна.
- » Өмнөговь, Дорноговь аймгийн багууд, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын бүсэд ажилладаг анхан шатны эмнэлгийн ажилтнуудад шаардлагатай эрүүл мэндийн тусламжийн хэрэгслийг нийлүүлэх.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/291 тоот тушаалд дурдсан байдаг бөгөөд дараах хэрэгсэл ордог.

Үүнд:

- Интернэтэд нэвтрэх боломжтой зөөврийн таблет,
  - Импульсийн оксиметр,
  - Жинлүүр,
  - Сфигмоманометр эсвэл цусны даралт хэмжигч,
  - Чагнуур,
  - Халуун хэмжигч,
  - Цусан дахь сахар, холестериньн түргэн оношлуур.
- » Алсын зайнаас жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон Zoom, Mn.Obstetrics зэрэгтэй дүйцэх Эрүүл мэндийн яамнаас баталсан программ хангамжийг ашиглан эмч нарт сургалт орно.

## Бусад санаачилга

"Оюу толгой" компани, нийт ажилтны зүгээс КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх үйлсэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 455 сая төгрөгийн хандив өргөсөн юм. Үүнээс 100 сая төгрөгийг Монголын Уул уурхайн үндэсний ассоциациар дамжуулж Монгол Улсын Засгийн газарт, 200 сая төгрөгийг Өмнөговь аймгийн Онцгой комисс, 10 сая төгрөгийг "Говийн Оюу" Хөгжлийг Дэмжих Сангаар дамжуулж Ханбогд сумын Онцгой комисст хандивласан. Оюу толгойн уурхайчид хандивын аян өрнүүлсний дүнд цугларсан 145 сая төгрөгийг Эрүүл мэндийн яаманд мөн хандивласан. Энэхүү хандивын аянд Оюу толгойн гэрээт 38 компанийн ажилчид оролцсон билээ.

## Төлөөлөн удирдах зөвлөл

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

#### Галсангийн Батсүх

2010 оны зургаадугаар сард томилогдсон

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

#### Армандо Торрес

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал  
2017 оны тавдугаар сард томилогдсон

#### Нацагийн Багабанди

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2016 оны есдүгээр сард дахин томилогдсон

#### Баатарын Болд

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2021 оны хоёрдугаар сард томилогдсон\*\*

#### Элиас Скафидас

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2018 оны есдүгээр сард томилогдсон

#### Стив Тибоуг

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2021 оны гуравдугаар сард томилогдсон \*\*\*

#### Люк Колтон

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2018 оны дөрөвдүгээр сард томилогдсон

#### Энхбаатарын Баясгалан

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2020 оны арван нэгдүгээр сард томилогдсон\*

#### Зундуйсүрэнгийн Ган-Очир

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
2020 оны арван нэгдүгээр сард томилогдсон\*

## Гүйцэтгэх удирдлагын баг

#### Армандо Торрес

Гүйцэтгэх захирал  
2017 оны тавдугаар сард томилогдсон

#### Тим Экерсли

Уурхайн үйл ажиллагаа хариуцсан захирал  
2018 оны нэгдүгээр сард томилогдсон

#### Жак Ван Тондер

Гүний уурхайн төслийн захирал  
2020 оны арван хоёрдугаар сард томилогдсон

#### Пол Мюллинс

Санхүү хариуцсан захирал  
2017 оны тавдугаар сард томилогдсон

#### Дашнямын Амарбаясгалан

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал  
2014 оны аравдугаар сард томилогдсон

#### Шуркагийн Байгалмаа

Стратегийн орон нутгийн төслүүд хариуцсан ерөнхий менежер  
2019 оны зургаадугаар сард томилогдсон

#### Крис Эйчисон

Гүний уурхайн төслийн удирдагч  
2020 оны нэгдүгээр сард томилогдсон

#### Филип Абрахам

ЭМААБОАБ-ын асуудал хариуцсан ерөнхий менежер  
2020 оны наймдугаар сард томилогдсон

#### Мелисса Шаненганге

Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер  
2020 оны есдүгээр сард томилогдсон

#### Гарет Жонстөүн

Хамтын ажиллагаа, мэдээлэл, харилцааны газрын Ерөнхий менежер  
2021 оны хоёрдугаар сард томилогдсон\*\*\*\*

#### Цэрэвсүрэнгийн Цэрэнхүү

Компанийн Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  
2010 оны наймдугаар сард томилогдсон

\* 2020 оны 11-р сарын 9-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор Цэвэгмидийн Түмэнцогт, Цэрэнгийн Сүхбаатар нарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, Зундуйсүрэнгийн Ган-Очир, Энхбаатарын Баясгалан нарыг ТУЗ-ийн гишүүнээр томилов.

\*\* 2021 оны 2-р сарын 5-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор Арнауд Суаратыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, Баатарын Болдыг ТУЗ-ийн гишүүнээр томилов.

\*\*\* 2021 оны 3-р сарын 5-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор Улф Куэлманыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, Стив Тибоуг ТУЗ-ийн гишүүнээр томилов.

\*\*\*\* 2020 оны есдүгээр сараас 2021 оны хоёрдугаар сар хүртэл Эрдэнийн Лхагва Хамтын ажиллагаа, мэдээлэл, харилцааны газрын Ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэсэн.

# 2020 оны ТУЗ, хороод, хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОВЧООН

## **Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Хувьцаа эзэмшигчдийн 17-р хурал – 2020 оны 4-р сарын 29 (ээлжит ерөнхий хурал)

## **Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал**

40-р хурал – 2020 оны 3-р сарын 5

41-р хурал – 2020 оны 6-р сарын 10 ба 18

42-р хурал – 2020 оны 9-р сарын 9

43-р хурал – 2020 оны 11-р сарын 25 ба 30

## **Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал**

Ээлжит бус 30-р хурал – 2020 оны 2-р сарын 11

Ээлжит бус 31-р хурал – 2020 оны 3-р сарын 18

Ээлжит бус 32-р хурал – 2020 оны 4-р сарын 14

Ээлжит бус 33-р хурал – 2020 оны 5-р сарын 1

Ээлжит бус 34-р хурал – 2020 оны 5-р сарын 8

Ээлжит бус 35-р хурал – 2020 оны 5-р сарын 15

Ээлжит бус 36-р хурал – 2020 оны 5-р сарын 21 ба 29, 6-р сарын 4

Ээлжит бус 37-р хурал – 2020 оны 6-р сарын 26

Ээлжит бус 38-р хурал – 2020 оны 7-р сарын 8

Ээлжит бус 39-р хурал – 2020 оны 11-р сарын 13

Ээлжит бус 40-р хурал – 2020 оны 12-р сарын 17

## **Аудит, санхүүгийн хороо (АСХ) -ны хурал**

АСХ-ны 39-р хурал – 2020 оны 3-р сарын 4

АСХ-ны 40-р хурал – 2020 оны 6-р сарын 9

АСХ-ны 41-р хурал – 2020 оны 9-р сарын 8

АСХ-ны 42-р хурал – 2020 оны 11-р сарын 24

## **Үйл ажиллагааны хороо (ҮАХ) -ны хурал**

ҮАХ-ны 36-р хурал – 2020 оны 3-р сарын 4

ҮАХ-ны 37-р хурал – 2020 оны 6-р сарын 9

ҮАХ-ны 38-р хурал – 2020 оны 9-р сарын 8

ҮАХ-ны 39-р хурал – 2020 оны 11-р сарын 24

## **Хүний нөөц, сургалтын хороо (ХНСХ) -ны хурал**

ХНСХ-ны 38-р хурал – 2020 оны 3-р сарын 4

ХНСХ-ны 39-р хурал – 2020 оны 6-р сарын 9

ХНСХ-ны 40-р хурал – 2020 оны 9-р сарын 8

ХНСХ-ны 41-р хурал – 2020 оны 11-р сарын 24

## **Хамтын ажиллагааны хороо (ХАХ) -ны хурал**

ХАХ-ны 11-р хурал – 2020 оны 3-р сарын 4

ХАХ-ны 12-р хурал – 2020 оны 6-р сарын 9

ХАХ-ны 13-р хурал – 2020 оны 9-р сарын 8

ХАХ-ны 14-р хурал – 2020 оны 11-р сарын 24

